



**Монгол улс, Уул уурхайн
ям:**

**Монгол улсын
Ашигт малтмалын баялаг,
нөөцийн ангилал**

**Төслийн дугаар No. AU4417
2014 оны 12-р сар**

Эцсийн тайлан

3 Монгол улсын Тайлагнах ангилал(МТ)

Эрх зүйн хүрээ бүрт, “хөрөнгө оруулагчид буюу чадвартай хөрөнгө оруулагчид, тэдгээрийн зөвлөхүүдэд хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг болон Ордын нөөцийн талаар мэдээлэх зориулалт”-аар³ уул уурхайн компаниудаас гаргасан Нийтэд тайлагнах тайландаа CRIRSCO ангиллыг хэрэглэнэ. Энэ ангилал нь уул уурхайн компаний дотоод практик үйл ажиллагаатай зөрчилдөхгүй, зөвхөн нийтэд зориулсан тайланд хэрэглэгдэнэ.

Монгол улсын Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал (МТ) нь CRIRSCO-д хамаарах Ангилалтай тохирсон бөгөөд Монгол улсад болон гадаадад өргөнөөр ойлгогдож танигдсан техник мэдээллийг уул уурхайн хөрөнгө оруулагчдад өгдөг.

3.1 Өмнөх тайлагнах тогтолцоо

Монгол улсын уул уурхайн төслүүд өмнө нь Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг уламжлалт Зөвлөлтийн тогтолцооны дагуу тооцоолж байжээ. Энэ тогтолцоо нь тухайн төсөлд хамаарах түүхий эдийн тоо хэмжээг л зарим нэг баталгаатай гаргаж байсан болохоос биш, харин байнга хувьсан өөрчлөгдөж байгаа эдийн засгийн нөхцөл байдал болон дараа нь эхлэх боловсруулах ажлын эдийн засгийн талаар анхаарч байгаагүй байна.

Геологийн тооцоо үнэлгээний ажиллагаа нь 1960-аад онд Оросын ангилал боловсруулагдсанаас хойш мэдэгдэхүйц урагшилсан бөгөөд энэ нь 80-аад онд дахин шинэчлэгдсэн байна. CRIRSCO ангилал нь Ордын нөөцийг үнэлэхэд хэрэглэгддэг арга, аргачлалыг тайлбарладаггүй хэдий ч одоо ашиглаж буй хамгийн сайн олон улсын практикийг илэрхийлдэг.

3.2 CRIRSCO-д хамаарах Ангиллын давуу тал

CRIRSCO-д хамаарах Ангилал хэрэглэсний давуу тал нь:

Монгол улсын уул уурхайн төслүүдтэй холбоотой эдийн засгийн эрсдэлийн бууралт

Эдийн засгийн эрсдэлийн бууралт нь уул уурхайн бусад голлох хүрээнд CRIRSCO-д хамаарах Ангилал хэрэглэсний үр дүнгээс харагдана:

- Австралид, 1989 онд Австралийн Хөрөнгийн Биржээр дамжуулан тус улсын Ангилал (ЖОПКСтандарт) хэрэглэснээс хойш Ашигт малтмалын баялаг, ордын нөөцөд ноцтой луйврын шинжтэй үйлдэл гараагүй байна. Иргэний шүүхээр амжилттай шийдэгдсэн луйврын жижигхэн хэргүүд л гарсан байна.
- Канадад, Канадын Засгийн газраас 1996 онд тухайн Улсын Ангилал (NI43-101) хэрэглэснээс хойш Ашигт малтмалын баялаг, ордын нөөцөд ноцтой луйвар гараагүй байна. Хувь хүмүүс тухайн Ангиллыг албан ёсны сорилт маягаар ашиглан луйврын мэдэгдэл гаргасан хэд хэдэн хэргийг амжилттай шийдвэрлэсэн. Эдгээр нь шинэхэн уул уурхайн компаниудыг оролцуулсан бөгөөд ноцтой бус байв.

³ CRIRSCO International Reporting Template, May 2013, Clause

Монгол улсын уул уурхайн төслүүдийн хөрөнгийн зардлын бууралт:

Харьцангуй цөөн хүн аМТй, нөөцөөр баян орнууд, тухайлбал Канад, Австрали нь уул уурхайн үйлдвэрлэлээ хөгжүүлэх, үндэсний оролдлого бий болгохдоо ихэвчлэн гадны хөрөнгөнөөс хамааралтай байдаг. Энэхүү хөрөнгийн ихэнхийг санхүүгийн томоохон байгууллагууд эсвэл үндэсний дээд хэмжээний баялгийн сангаас гардаг.

Хөрөнгө оруулагчид нь энэхүү хөрөнгийн хүүгийн хэмжээг тавьдаг. Бусад хүчин зүйлээс хүүгийн хэмжээ нь хүлээн зөвшөөрөгдсөн төслүүд болон үндэсний эрсдэлд хамаарна. CRIRSCO Ангилал нь төсөл болон үндэсний эрсдэлийг илүү ил тод судалдаг гэж хөрөнгө оруулагчид хардаг тул энэ Ангиллын дагуу ашигт малтмалын баялаг болоннөөцөө илэрхийлдэг улс орнуудын хувьд эрсдэлийн хэмжээ илүү бага, үүнтэй холбогдон хүүгийн хэмжээ ч илүү бага байдаг.

Энэхүү ангилал нь ил тод байдал болон санхүүгийн зах зээлд ойлгомжтой болсон эрсдэлийг тайлагнадаг материалын талаар бичүүлдэг.

Монгол улсын уул уурхайн үйлдвэрлэлийн хөгжилд өсөн нэмэгдэх хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулагчдын анхаарлыг эрсдлийг зөв тооцож хэлэлцсэн төслүүд татдаг. CRIRSCO Ангиллын дагуу Ордын нөөцийг үзүүлснээр хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монгол улсын төслүүдэд илүү татах бөгөөд ингэснээр Монгол улсын хүн амд зориулсан үйлдвэрлэлд итгэх итгэл болон ДНБ өсөх болно.

3.3 МТ-ын загвар

2011 оны MSISTAP-#2.2/29 Гэрээнд тусгагдсан Сновдений анхны аргачлал нь CRIRSCO Ангиллын цор ганц Монгол хувилбарыг боловсруулах оролдлого байлаа. Одоогийн Гэрээг эхлэх үед, ийм Ангилал нь CRIRSCO-оос онцгойлон, цаг хугацаа зарцуулан хянаж, санал өгөхийг шаарддаг тул энэ аргачлал дутагдалтай болох нь илэрхий болсон. Одоогийн Гэрээний төсөв болон хугацааны хязгаарлалтаас болж CRIRSCO-ын Ангиллын загварыг⁴ монгол хэл рүү үг нэг бүрчлэн орчуулж хэрэглэхээр шийдвэрлэсэн.

Энэ ажлыг МГУУМИ-ийн хатагтай Гэрлээ Баянжаргал 2014 оны 6-8 сарын хооронд хийж, эхний төсөл баримт бичгийг санал авахаар CRIRSCO руу 2014 оны 6 сарын сүүлээр явуулсан. CRIRSCO-ийн гишүүдийн санал 2014 оны 8 сарын сүүлээр бэлэн болсон бөгөөд эцсийн МТ-ын баримт бичгийг орчуулж, 2014 оны 9 сард Монгол улсын Засгийн газарт өргөн барьж батлуулсан болно.

⁴ <http://www.criirSCO.com/template.asp>

4 “Зохицуулах баримт бичиг”

Өмнөх геологийн ажлын ололт амжилтыг үгүйсгэхгүйгээр CRIRSCO Ангиллыг нэвтрүүлэхийн тулд Монгол улсын Ашигт малтмал, Ордын нөөцийг CRIRSCO Ангилал руу хөрвүүлэхэд мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага шаардлагатай болсон. Үүнийг “зохицуулах баримт бичиг” гэж эш татсан болно.

4.1 Оросын зохицуулах баримт бичиг

Ангилалтай хамт, Сновдений өмнөх туршлага болон гэрээний хязгаарлалт нь шинэ зохицуулах баримт бичиг боловсруулахаас зайлсхийн одоо байгаа зохицуулах баримт бичиг 2010-08-25-ны өдрийн “*Оросын Ордын нөөцийн тайлангийн стандарт болон CRIRSCO Загварыг тохируулах гарын авлага*”-ыг тааруулж нийцүүлэхэд хүргэсэн.

Дараах шалтгааны улмаас энэ баримт бичгийг сонгосон. Үүнд:

- үүнийг CRIRSCO аль хэдийнээхүлээн зөвшөөрсөн
- Монгол улсын болон Оросын ангилал нь хоорондоо маш төсөөтэй.

4.2 Монголын зохицуулах баримт бичиг

Энэ баримт бичиг нь оросоос монгол, англи хэл рүү орчуулахад цаг зарцуулсан нүсэр хөдөлмөр болох, хатагтай Баянжаргалын мэргэжлийн тусгай мэдлэг шаардлагатай байсныг бататгасан.

Зохицуулах баримт бичиг 2014 оны 11 сард бэлэн болж, МГУУМИ-ийн гишүүдийн семинар дээр тавигдсан.

5 Сургалт

Сновден урьдчилсан сургалт семинаруудыг Улаанбаатар дахь МГУУМИ дээр 2014 оны 6 сард зохион байгуулсан бөгөөд МГУУМИ-ийн гишүүд болон сонирхсон талууд оролцсон. Сновден семинар дээр олон улсын ангилал, мэргэжлийн байгууллагуудын бүтэц, Ордын нөөцийн үнэлгээний олон улсын одоогийн практикийн талаар танилцуулсан. Эдгээр семинар нь англи хэл дээр явагдсан бөгөөд техник орчуулгыг хатагтай Баянжаргал хийсэн.

Дараа нь Сновден 2014 оны 10 сард CRIRSCO-д хамаатай МТ Нөөцийн ангилалд Монгол улсын нөөцийг “хөрвүүлэх” ажилд туслан Ангилал нэвтрүүлэлтийг хэрэгжүүлэх, Гэрээний хамрах хүрээг хэрэгжүүлж дуусгах зорилгоор CRIRSCO-ийн хуралд оролцсон. Энэ хуралд Сновден Монгол улсын ангилал болон үүний боловсруулалтын талаар CRIRSCO-ийн болон МГУУМИ-ийн гишүүд, Монгол улсын засгийн газрын албаны хүмүүс, сонирхогч талуудад танилцуулав.

Хамрах хүрээг хэрэгжүүлэхийн тулд Сновден МГУУМИ-ийн гишүүд болон сонирхогч талуудад зориулан төгсгөлийн сургалт семинарыг 2014 оны 11 сард танилцуулсан. Үүнийг хатагтай Баянжаргал хийсэн.

Монголын геологичид нь сонгодог үнэлгээний аргуудыг суралцсан бөгөөд одоогийн дадлыг эзэмшихэд цаашид сургалт явуулах шаардлагатай. Энэ нь мэргэжлийн хувь хүмүүст түвэгтэй биш боловч эдгээр мэргэжилтний зарим хэсэгт нь тусгайлан зориулах шаардлага гарах бөгөөд чадварлагаар ажилладаг болоход шаардлагатай мэдлэг чадвар олж авах, өөртөө итгэлтэй болоход тодорхой хугацаа хэрэгтэй.

6 Тайлбар

Сновден энэхүү Гэрээг гүйцэтгэснээр их зүйл сурсан бөгөөд CRIRSCO-д хамаатай ангиллыг хэрэгжүүлэх гэж байгаа бусад хүмүүс, үндэсний тайлагнадаг байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудад хэрэгтэй болов уу гэж үзэн өөрийн олж мэдсэн зүйлс, туршлага, ирээдүйн төлвийн талаар товч тайлбар хийсэн.

6.1 Тайлагнах ангилал, зохицуулах баримт бичиг

Цаашдын CRIRSCO Ангилал, аливаа шинэ эрх мэдлийн хүрээ нь CRIRSCO-ийн Загвар болон зохицуулах баримт бичгийг үг нэг бүрчлэн орчуулах (хэрэв шаардлагатай бөгөөд байгаа бол)-ыг хүлээдэг болохыг Сновден ерөнхийд нь илэрхийлсэн.

Энэ аргачлал нь CRIRSCO-д хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд шинэ Ангиллын хувьд удирдлагын болон боловсруулалтын шаардлагыг багасгадаг. CRIRSCO-оор Ангиллыг хүлээн зөвшөөрүүлснээр тухайн эрх мэдлийн хүрээ нь орон нутгийн нөхцөл байдалд тохируулахаар Ангиллаа туршлагынхаа үр дүнд тулгуурлан өөрчлөн шинэчилж болох ба энэ өөрчлөлт нь CRIRSCO-д хүлээн зөвшөөрөгдөхүйц, CRIRSCO-ийн бодлогод нийцсэн байна.

6.2 Үндэсний тайлагнах байгууллагууд ба мэргэжлийн байгууллагууд

Мэргэжлийн байгууллагуудтайгээр CRIRSCO-г нэвтрүүлэх эрх мэдлийн хүрээнд, тавигдах гол шаардлага нь хууль сахиулах Сахилгын ангилал юм. Байгуулагдсан олон улсын байгууллагууд (жишээлбэл Австралид AusIMM-Ашигт Малтмалын Хүрээлэн; Канадад янз бүрийн мужийн байгууллагууд; Өмнөд Африкт SAIMM-Өмнөд Африкийн Уул уурхай, металлургийн хүрээлэн) нь өөрийн эрх олгох бичиг, дүрмээ хэвлүүлсэн байдаг бөгөөд шинээр байгуулагдах эрх мэдлийн хүрээ эдгээрээс хуулж хэрэглэхийг Сновден зөвлөж байна.

Үндэсний тайлагнах байгууллагын гол асуудал нь тодорхой эрх мэдлийн хүрээнд цорын ганц онцгой эрхтэй тайлагнах байгууллага гэдгээ таниулах явдал юм. Барууны либералчлагдсан нийгмийн хувьд, үүнийг холбогдох хөрөнгийн биржийн Жагсаалтын дүрмээр зохицуулдаг ба төрийн захиргааны агентлагууд энэхүү Дүрэм, Ангиллыг арилжааны хууль тогтоомжийн доор сорилт маягаар хэрэглэдэг. Бусад эрх мэдлийн хүрээнд, тухайлбал Монгол улсын хувьд Ангиллыг нэвтрүүлэхэд улс төрийн дэмжлэг шаардлагатай байж болох засгийн газрын зөвшөөрөл авах хэрэгтэй.

МГУУМИ-ийн сайшаахуйц санаачлага нь Гишүүдийнхээ мэргэжлийн боловсролыг дээшлүүлэх юм. МГУУМИ нь Гишүүдийнхээ ашиг сонирхолд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд дээрх санаачлага нь үүнийг дэмжих юм. Мэргэжил дээшлүүлэх бүтэц нь AusIMM-ийн бүтцийн ихэнх хэсэгтэй таарч байгаа бөгөөд бусад эрх мэдлийн хүрээ үүнийг дагаж мөрдөхийг хүсч болно.

6.3 Гэрээний дуусгавар

MSISTAP-#2/29 гэрээний шаардлага нь Ангилал болон CRIRSCO-г хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг 2014 оны 10 сард багтаан гүйцэтгэх ёстой байв. Илүү бодит байдлаар үзүүлэхийн тулд Сновдений тухайн үед боловсруулсан “Шаардлагатай баримт бичиг” нэртэй бичигт харуулсан үе шатны хэлбэрээр хамрах хүрээг өөрчлөх зорилгоор 2014 оны 6 сард Монголын Уул уурхайн газартай гэрээ хэлэлцээр хийсэн.

Тус Гэрээг дараа нь 2014-10-20-ний өдрийн өөрчлөлтөөр 2014 оны 11 сар хүртэл сунгасан.

Хэрэглэгдэхүйцбаримт бичгийн “Зөвлөмж” бүлэг дэх тайлбар болон хэрэгжилтийг налуу үсгээр доор дахин давтаж бичлээ:

1. МГУУМИнь өөрийн дүрэм, ёс зүйн болон сахилгын журмаа боловсруулж, эдгээрийг Яаманд дэмжлэг авахаар, CRIRSCO-д батлуулахаар явуулна.
Энэ нь хийгдсэн бөгөөд Яам, CRIRSCO руу явуулж дэмжигдсэн.
 - a. МГУУМИнь Итгэмжлэгдсэн мэргэжилтэн/Чадавхтай ажилтныг олж таних журам боловсруулна. Энэ нь CRIRSCO-д хэрэгтэй шат биш боловч МГУУМИ-ийн дотоод хэрэг бөгөөд зэрэг шийдэж болох юм.
Энэ баримт бичгийг боловсруулж байгаа бөгөөд МГУУМИ-ийн дотоод хэрэг, хамрах хүрээнд хамааралгүй. Сновден сайхан сэтгэл гаргаж тусалсан болно.
 - b. МГУУМИнь AusIMM, SAIMM, CIM, NAEN гэх мэт болон бусад ижил төрлийн байгууллагуудтай далайн чанадах хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын мэргэжлийн байгууллагын харилцааг бий болгоно. Үүндихээхэн хугацаа шаардлагатай байж болох бөгөөд CRIRSCO-г хүлээн зөвшөөрөхөд садаа болохгүй.
Энэ нь МГУУМИ-ийн дотоод хэрэг бөгөөд хамрах хүрээнд хамааралгүй. Сновден сайхан сэтгэл гаргаж тусалсан болно.
2. МГУУМИнь CRIRSCO-д хамаатай Ашигт малтмалын ангиллыг бүрдүүлж, Яамаар батлуулснаар CRIRSCO-ийн Загвараар тогтоосон Нийтэд тайлагнах тайланд зөвхөн зөвшөөрөгдсөн Ангилал болно.
Хийгдсэн .
3. МГУУМИ-ийн гишүүд, Яам, Монголын Хөрөнгийн бирж, Их сургуулийн төлөөлөл гишүүд бүхий Үндэсний тайлагнах байгууллага (NRO) байгуулах. JORC Хороо гэх мэт ижил төсөөтэй байгууллагын мэргэжилтэнг энэ зорилгоор хэрэглэхийг зөвлөж байна.
Хийгдсэн .
4. Хуучны Оросод тулгуурласан Монголын тогтолцооны ангилал болон CRIRSCO-ийн тодорхойлолтод хамаарах “Зохицуулах баримт бичиг” боловсруулах.
Хийгдсэн .

5. МГУУМИ-ийг Яамаар дэмжүүлэх.

Хийгдсэн .

6. Үндэсний тайлагнах байгууллагыг Яамаар дэмжүүлэх.

Хийгдсэн .

7. Ангилал болон Зохицуулах баримт бичгийг Яамаар дэмжүүлэх.

Хийгдсэн .

8. Монгол улсын Ордын нөөцийн ангиллын хуулбар болон дээр дурдсан 5, 6, 7-р зүйлийн хуулбарыг агуулсан албан бичгийг Яамны Сайд дэмжиж, Яамаар дамжуулан CRIRSCO руу явуулна. Энэ бичигтэй хамт МГУУМИ-ийн Ерөнхийлөгчийн дэмжсэн, өөрийн бүтэц, дүрэм, ёсзүйн болон сахилгын журмын тухай тайлбар бүхий баримт бичгийг хамт явуулна.

Хийгдсэн .

9. Үндэсний тайлагнах байгууллагын урьдчилсан уулзалт. Үнэмлэх мандат, журам болон бусад асуудлыг тогтоох зорилготой Монгол улсын Үндэсний тайлагнах байгууллагад сонгогдсон гишүүдийн хурал болсон.

Хийгдсэн

10. Ангилал болон Зохицуулах баримт бичгийг танилцуулах сургалт семинар.

Хийгдсэн .

Иймээс Сновден MSISTAP- #2/29 Гэрээ амжилттай хэрэгжүүлснийг мэдэгдэхдээ таатай байна.

7 Талархал

Сновден энэхүү Гэрээг амжилттай хэрэгжүүлж дуусгахад дараах хүмүүсийн оруулсан хувь нэмэр болон цаг хугацааг баяртайгаар талархаж байна. Үсгийн дарааллаар:

- Хатагтай Гэрлээ Баянжаргал
- Ноён Харри Паркер
- Ноён Ивор Жонс
- МГУУМИ-ийн Гишүүд, Хороо.

Хавсралт А Заавар баримт бичиг:

**Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын
баялаг, ордын нөөц (МТ Ангилал)-ийг Нийтэд
тайлагнах Монгол улсын Ангилал**

Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг Нийтэд тайлагнах Монгол улсын Ангилал (МТАнгилал)

2014

ӨМНӨХ ҮГ

1. Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг Нийтэд тайлагнах Монгол улсын Ангилал (цаашид МТ Ангилал гэх болно)-ыг Ордын нөөцтайлагнах олон улсын стандартын хороо (CRIRSCO) болон Монгол улсын Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл (МЭБМЗ)-ийн оролцоотойгоор Монгол улсын Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн хороо (MRC), Монголын Геологи уул уурхайн институт (МГУИИ) боловсруулсан байна.

МТ Ангилал нь Монгол улсын уул уурхайн болон хайгуулын компаниуд (цаашид Компани гэх болно)-аас Нийтэд тайлагнахад тавигдах доод шаардлагыг тогтоодог. МТ Ангиллыг дэлхийн уул уурхайн нийгэмлэг (Австралази, Канад, Өмнөд Африк, АНУ, Чили, Европ, Орос)-т хүлээн зөвшөөрөгдсөн ерөнхий шалгуурын дагуу, Монгол улсын Ордын нөөц, ашигт малтмалын ангиллын тогтолцоо болон Хэрэглэгчийн зааврыг анхааран боловсруулсан болно.

ОРШИЛ

2. МТ Ангилалд онц чухал, заавал мөрдөх нэр томъёо, тэдгээрийн тодорхойлолтыг **тод** (bold) үсгээр тэмдэглэсэн. Удирдамж зааврыг холбогдох МТ Ангиллын заалт бүрийн ард *шинэ мөрнөөс* налуу (*italics*) үсгээр бичиж оруулсан. Эдгээр нь МТ Ангиллын заалтыг хэрэглэхэд зориулан уншигчдад тусламж, заавар өгнө.

Түүнчлэн Хавсралт 1 – “*Ерөнхий нэр томъёо ба ижил зүйлс*” болон Хүснэгт 1 - “*Үнэлгээ, Тайлагнах шалгуурын хуудас*” нь МТ Ангиллыг хэрэглэх зааврын салшгүй хэсэг болохыг тодорхой харуулахын тулд эдгээр хэсэгт налуу үсэг хэрэглэсэн.

Хүснэгт 1-д Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг тайлагнахдаа Чадавхтай ажилтны анхаарах ёстой асуудлуудыг тусгасан. Бусад хүмүүс хийж чадахгүй тул зөвхөн Мэргэшсэн этгээд нь асуудал бүрт нарийн тодорхой тайлбар өгөх хэрэгтэй.

Бичвэрт хэрэгцээгүүгээр давхардуулах буюу хоёрдмол утга гаргахгүйн үүднээс Хавсралт 1-д ерөнхий нэр томъёо ба тэдгээртэй ижил зүйлсийг оруулсан болно.

ЗАРЧИМ, ХАМРАХ ХҮРЭЭ

3. МТ Ангиллыг хэрэглэх, ашиглахад баримтлах гол зарчим нь ил тод, бодит болон нэр хүндтэй байдал юм.

Ил тод байдал нь Нийтэд тайлагнах тайланг хэрэглэгчид нарийн тодорхой, эргэлзээгүй мэдээллийг хангалттай өгөх, ингэснээр тайлан ойлгомжтой, төөрөгдөхөөргүй байх шаардлага юм. **Бодит байдал** нь Нийтэд тайлагнах тайланд хөрөнгө оруулагчдад хамаарах бүх мэдээллийг агуулах ба мөн тэдгээрийн мэргэжлийн зөвлөхтэй холбоотой мэдээлэл зайлшгүй шаардлагатай бөгөөд тайлагнасан Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, нөөцтэй холбогдуулан үл үндэстэй, сайтар тунгаасан дүгнэлт хийх боломж олгох шаардлага юм. **Нэр хүндтэй байдал** нь Нийтэд тайлагнах тайланг биеэ авч явах дүрэм болон ёс зүйн мэргэжлийн сахилгад захирагддаг, хангалттай мэргэшсэн, туршлагатай ажилтан хариуцан гүйцэтгэсэн ажилд тулгуурлахыг шаарддаг.

4. **Нийтэд тайлагнах тайланг хөрөнгө оруулагчид, боломжтой хөрөнгө оруулагчид, тэдгээрийн зөвлөхүүдэд Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн талаар мэдээлэл өгөх зориулалтаар боловсруулдаг. Энд Компаний жил, улирлын тайлан, хэвлэлийн мэдээ, мэдээллийн илтгэх хуудас, техникийн баримт бичиг, вэб-хуудсанд гаргасан зүйлс болон нийтэд тавьсан илтгэлүүд орох ба үүгээр хязгаарлагдахгүй.**

МТ Ангилал нь Нийтэд тайлагнах тайланд тавигдах доод стандарт бөгөөд бусад тайланд ч тавигдах доод стандарт болгон хэрэглэхийг зөвлөдөг. Компани нь Нийтэд тайлагнах тайландаа боломжийн хэрээр нарийн дэлгэрэнгүй мэдээлэл оруулах үүрэгтэй.

Төрийн захиргаанаас шаарддаг, Монгол улсын Засгийн газрын ангиллын тогтолцоог ашиглан гаргадаг тайланг МТ Ангиллын хүрээнд нийтэд тайлагнах тайлан гэж үзэхгүй.

МТ Ангиллыг нь мөн Бүлэг 4-т заасан зорилгоор боловсруулсан аливаа тайлан, тухайлбал Байгаль орчны мэдэгдэл, Мэдээллийн илтгэх хуудас, Экспертийн тайлан болон Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, нөөцөд хамаарах техникийн баримт бичигт хэрэглэнэ. Түүнчлэн эдгээр тайланг Монгол улсын Засгийн газраас тавигдах шаардлагыг хангах зорилгоор боловсруулж болно

Товч буюу жилийн тайлан, эсвэл бусад хураангуй тайлан гаргаж байгаа Компаний хувьд Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, нөөцтэй холбоотой бүх мэдээлэл материалыг оруулахыг зөвлөдөг. Хураангуй мэдээлэл үзүүлж байгаа тохиолдолд энэ нь товч хураангуй болох тухай тодорхой мэдэгдэж, уг хураангуйн үндэслэл болгосон Нийтэд тайлагнах тайлангийн стандарт буюу энэ стандартад нийцэж буй МТ Ангиллын эх үүсвэр, байршлыг зааж тусгасан хавсралтыг хавсаргах ёстой.

Компаний зүгээс нэг ба түүнээс дээш тооны захиргааны мэдэлтэнд энэхүү МТ Ангиллаас өөр байж болох стандартад нийцсэн тайлан гаргахыг шаарддаг болох нь ажиглагдсан. Тийм тайланд уншигчдад зориулан энэ нөхцөл байдлыг анхааруулсан тухай мэдэгдлийг оруулахыг зөвлөж байна.

“Баримт бичиг”-т хавсаргах МТ Ангиллын эшлэлийг Нийтэд тайлагнах тайлангийн үндэс тулгуур суурь болгон бэлтгэж Компанийн дотоод баримт бичигт хавсаргана.

Мэргэшсэн этгээд Компаний дотоод хэрэгт зориулан буюу нийтэд зориулалтгүйгээр баримт бичгийг боловсруулсан үед (Бүлэг 1-д хамаарна) МТ Ангилалд нийцэхгүй байх нөхцөл үүсч болох нь ажиглагдсан. Ийм нөхцөлд, тухайн баримт бичигт энэ талаар нүдэнд тусахуйц мэдэгдэл оруулахыг зөвлөж байна. МТ Ангилал нь чадавхтай ажилтны боловсруулсан Нийтэд тайлагнах тайланд Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, нөөцийн үнэлгээ, суурь баримт бичгийг шударгаар үзүүлэхийг шаарддаг тул энэхүү нэмэлт мэдэгдэл нь шаардлагад нийцээгүй баримт бичгийг Нийтэд тайлагнах тайланд нийцүүлэн хэрэглэх боломжийг багасгаж байгаа юм.


МТ Ангиллын хүрээнд хийгдэж буй ажил хэрэг бүр нь Нийтэд тайлагнахад тааралдаж болох бүхий л нөхцөл байдлыг шийдэхээр хийгддэг тул холбогдох хэлбэрээр илрэх эргэлзээ гарах тохиолдол байж болно. Тийм тохиолдолд, МТ Ангиллын хэрэглэгчид болон тайлангаа МТ Ангилалд нийцүүлэн хийж байгаа хүмүүст Нийтэд тайлагнахад тавигдах доод стандартыг танилцуулж, тийм тайланд хөрөнгө оруулагчид, тэдгээрийн зөвлөхүүдтэй холбоотой бүх мэдээллийг оруулсан байхыг шаарддаг, тайлагнаж буй Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, нөөцтэй холбогдуулан ул үндэстэй, нягт дүгнэлт хийхэд зориулагдсан мэдээллийг нарийн багтаасан байх тухай зааварлавал зохино.

Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн үнэлгээ нь өөрийн мөн чанараараа тодорхой хэмжээний эргэлзээтэй, нарийвчлалгүй байдаг. Мэдээллийн эх үүсвэрүүд, тухайлбал геологийн зураг, ашигт малтмалын ордын ердөө жаахан хэсгийг төлөөлөх дээжинд хийсэн шинжилгээний үр дүн гэх мэтийг тайлахад маш өндөр дадал туршлага хэрэгтэй байж болно. Үнэлгээний эргэлзээний талаар Нийтэд тайлагнах

тайлангийн материалд болон баримт бичигт онцлон авч үзэж, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн категориоос тохирохыг сонгон тусгавал зохино.

5. Холбогдох төрийн захиргааны агентлагаас Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн нийтэд тайлагнах шаардлагатай алмаз, бусад өнгөт чулуу, үйлдвэрлэлийн эрдэс, чулуу, бөөн чулуулаг, нүүрс гэх зэргийг багтаасан бүх төрлийн хатуу ашигт малтмалд МТ Ангиллыг ашиглана.
6. МТ Ангиллыг цаашид байнга хянан шинэчилж байх хэрэгтэйг хүлээн зөвшөөрсөн.
7. МТ Ангиллын Стандарт тодорхойлолтуудыг МТ Ангиллын Зураг 1–тэй хамт нь анхаарах ёстой. Дараах бичвэрт тодорхойлолтуудыг тодоор бичлээ. Тодорхойлсон нэр томъёо (бусад тодорхойлолтод эш татсан бол)-ны доогуур зурсан болно.

Зураг 1. Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг болон ордын нөөцийн хоорондох ерөнхий харилцан уялдаа



Мэргэшсэн этгээд нь Монгол улсын төрийн тайланд ашиглагддаг Монголын Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллын категори руу хөрвүүлэхдээ "Монгол улсын Тайлагнах стандарт болон МТ Ангиллыг тохируулах заавар удирдамж"-ийг Монголын үзүүлэн зураглал болон МТ Ангиллын тогтолцоог өгөх тулгуур материал болгон ашиглаж болно.

Гэхдээ, хоёр тогтолцооны категоруудыг тааруулах ажлыг механикаар хийгүй, харин чандавхтай ажилтны мэргэжлийн үндэслэлтэй шүүлт дүгнэлт дээр тулгуурлан дараа нь бодит орд газрын хувьд бататгаж, өөрчлөх удирдамж байх ёстой гэдгийг тэмдэглэх ёстой.

УР ЧАДВАР, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

8. Компаний Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцөд хамаатай Нийтэд тайлагнах тайлан нь Компаний гүйцэтгэгч Захирлуудын зөвлөлийн үүрэг хариуцлага юм. Аливаа ийм тайлан нь чадавхтай ажилтны бэлтгэсэн баримт материал, мэдээлэл дээр тулгуурласан, үнэн зөв байх ёстой.
9. Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн талаарх Нийтэд тайлагнах тайланд үндэслэл болгосон Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг,

ордын нөөцийнтооцоог нарийвчлан үзүүлсэн баримт бичгийг Мэргэшсэн этгээд өөрөө буюу шууд удирдлаганд нь боловсруулжогноо, гарын үсэг тавьсан байх ёстой. Энэхүү баримт бичигт тайлагнаж буй Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн талаар хангалттай сайн үзүүлсэн байх ёстой.

10. Нийтэд тайлагнах тайлан гаргаж буй Компани нь Мэргэшсэн этгээдийн нэр, боловсрол, мэргэжлийн болон ажлын мэдээлэл, холбогдох туршлагыг ил тод бичвэл зохино. Тайланг чадавхтай ажилтны өгөгдсөн маягт буюу нэмэлт бичвэрийн дагуу гараар бичсэн зөвшөөрлийн бичгийн хамт гаргах ёстой.
11. **Мэргэшсэн этгээд гэдэг нь ашигт малтмалын үйлдвэрлэлийн мэргэжилтэн, Монголын Геологи, уул уурхайн институтын буюу хүлээн зөвшөөрөгдсөн Мэргэжлийн байгууллагын Мэргэжлийн бүртгэлийн гэрчилгээ бүхий Гишүүн буюу хамтран зүтгэгч байна. Эдгээр байгууллага нь гишүүнийг түдгэлзүүлэх, татгалзах эрх мэдэл бүхий хууль сахиулах үйл явцыг хэрэгжүүлдэг.**

Мэргэшсэн этгээд нь эрдэсжилтийн хэлбэр, ордын төрлийн талаар доод тал нь 5-аас доошгүй жилийн мэдлэг туршлагатай, идэвхтэй ажилласан байх ёстой.

Хэрэв Мэргэшсэн этгээд нь Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан бичиж байгаа бол хайгуулын ажлын талаар холбогдох дадлага туршлагатай байх ёстой. Хэрэв Мэргэшсэн этгээд нь Ашигт малтмалын нөөцийн үнэлгээг тооцоолох буюу хяналт хийж байгаа бол ашигт малтмалын нөөцийн тооцоо, үнэлгээ, бодолт, эдийн засгийн олборлолтын талаар холбогдох дадлага туршлагатай байх ёстой.

Мэргэшсэн этгээдийн тодорхойлолтод байх гол шалгуур тодорхойлогч бол “холбогдох” гэсэн үг юм. Холбогдох дадлага туршлага нь юунаас бүрдэх вэ гэдэг тодорхойлолт нь хэцүү сэдэв бөгөөд эрүүл ухаанар хөгжүүлэх хэрэгтэй. Жишээлбэл, алтны судлын эрдэсжилт, том цул алттай тохиолдолд, цагаан тугалга, уран гэх мэт эрдсийн судлархаг хэлбэрийн эрдэсжилтийн хувьд ашигт малтмалын нөөцийг тооцоолоход өнгөт металлын ордын талаарх дадлага туршлага хамаатай байж магадгүй юм. Хоёр дахь жишээний хувьд алтны тунамал/шороон ордын ашигт малтмалын нөөцийг тооцоолоход тохирох Чадавхтай ажилтныг сонгохдоо энэ төрлийн эрдэсжилтийн тооцоо, эдийн засгийн олборлолтын талаар (магадгүй доод тал нь 5 жилийн) арвин туршлагатай байх хэрэгтэй. Энэ нь шороон ордын алтны онцлог шинж чанар, бага агуулга, агуулагч тунамлын ширхэгэлэлийн бүтэц, тэй холбоотой юм. Алтнаас бусад эрдэс агуулсан шороон ордын хувьд холбогдох дадлага туршлагатай байхыг шаардахгүй байж болно.

“Холбогдох” гэдэг гол үг нь, хэрэв тухайн хүн бусад төрлийн ордын талаар холбогдох дадлага туршлагатай бол Мэргэшсэн этгээд болохын тулд заавал тухайн төрлийн орд бүрийн хувьд 5 жилийн дадлага туршлагатай байх албагүй гэсэн утгатай. Жишээ нь, төмөрлөгийн хүдрийн янз бүрийн төрлийн үндсэн ордын нөөцийг тооцоолсон 20 жилийн (гэж бодъё) дадлага туршлагатай хүний хувьд зэсийн порфир орд (гэж бодъё) дээр чадавхтай хүнээр ажиллуулахын тулд заавал 5 жилийн тусгай дадлага туршлага шаардахгүй байж болно. Бусад төрлийн ордод дадлага туршлагатай бол порфир-зэсийн ордод хамаатай дадлага туршлага шаардаж болно.

Хайгуулын ажлын үр дүн буюу ашигт малтмалын нөөцийн үнэлгээг хариуцан гүйцэтгэж байгаа Мэргэшсэн этгээдийн хувьд эрдэсжилтийн төрлүүдийн талаарх дадлага туршлагаас гадна холбогдох ордын дээжлэлт, шинжилгээний арга техникийн талаар хангалттай туршлагатай байж, өгөгдлийн найдвартай байдалд нөлөөлж болохуйц асуудал бэрхшээлийг мэддэг, анхаардаг байвал зохино. Тухайн ордод ашиглаж болох олборлолт, баяжуулалтын арга техникийг зарим талаар үнэлдэг байх нь бас чухал.

Ерөнхий зааврын хувьд, Мэргэшсэн этгээдэд нэр дэвшиж буй хүн нь өөрсдийн зиндаа ижил хүмүүстэй нүүр тулж болох, нийгэмд ур чадвараа болон ордын төрөл, нөхцөл байдлыг

мэддэг тухайгаа харуулах талаар өөртөө итгэлтэй байвал зохино.

Ашигт малтмалын нөөцийг тооцоолох нь багийн ажил (жишээлбэл, өгөгдөл цуглуулахад нэг хүнийг буюу баг татан оролцуулах, тооцоо хийхэд өөр хүн буюу багийг оруулах) байж болно. Ашигт малтмалын нөөцийг тооцоолоход хэд хэдэн техникийн чиглэл бүхий багийг ажиллуулах нь ихээхэн нийтлэг байдаг. Багт өөр өөрийнх нь үүрэг хариуцлагыг тодорхой тогтоосон үед Мэргэшсэн этгээд бүрийг, оруулах хувь нэмрийг нь болон тухайн хувь нэмэрт хүлээх үүрэг хариуцлагыг нь тодорхойлбол зохино. Хэрэв ганцхан Мэргэшсэн этгээд Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн баримт бичигт гарын үсэг зурдаг бол тэр хүн тухайн баримт бичгийг бүхэлд нь МТ Ангиллын дагуу хийх үүрэг, хариуцлага хүлээнэ. Энэ тохиолдолд хамгийн чухал зүйл бол Мэргэшсэн этгээд Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн тооцоог бүхэлд нь хариуцан гүйцэтгэх, бусад хүмүүс баримт бичгийг бүхэлд нь буюу хэсэгчлэн боловсруулахад туслах, бусад хувь нэмэр оруулагчдын ажил боломжийн байгаа зэргийг хүлээн зөвшөөрөх нь хангалттай.

Чадавхтай ажилтны мэргэжлийн ажилтай холбоотой гарах санал гомдлыг тухайн хүний харъяалагддаг Монголын Геологи уул уурхайн мэргэжлийн институт буюу хүлээн зөвшөөрөгдсөн Мэргэжлийн байгууллагын сахилгын журмын дагуу шийдвэрлэнэ. Зөрчлийг холбогдох сахилгын арга хэмжээний дагуу шүүх бөгөөд тодорхой нөхцөлд гишүүнчлэлийг түдгэлзэх буюу татгалзах арга хэмжээ байж болно.

НЭР ТОМЪЁО

- 12. Нөлөөлөгч хүчин зүйлс нь Ашигт малтмалын баялгийг Ордын нөөц рүү хувиргахад хэрэглэгддэг чухал хэрэглүүр юм. Үүнд уул уурхай, баяжуулалт, металлург, дэд бүтэц, эдийн засаг, зах зээл, хууль эрх зүй, байгаль орчин, нийгэм болон төрийн хүчин зүйлс орох ба үүгээр хязгаарлагдахгүй.**

Зураг 1-д геологийн үнэмшилт магадлалын өөр өөр түвшин, техник эдийн засгийн үнэлгээний өөр өөр зэрэгт хамаарах багтаамж, зэргийн тооцооны ангилах ерөнхий бүдүүвчийг харууллаа. Ашигт малтмалыг ерөнхийдөө бусад чиглэлээс авсан оролт бүхий геологийн мэдээлэл дээр үндэслэн тооцоолж болно. Боломжтой болон Бодитой Ордын нөөцийн багц (зураг 1-д тасархай зураасаар үзүүлсэн) болсон өөрчилсөн Ордын нөөц нь олборлолтод нөлөөлөх Нөлөөлөгч хүчин зүйлсийг анхааралдаа авахыг шаарддаг бөгөөд ихэнх тохиолдолд өргөн хүрээний чиглэлээс мэдээлэл авч тооцоолох нь зохистой.

Ордын Бодитой нөөцийг Баттай нөөц буюу эсвэл Магадлалтай нөөц рүү хөрвүүлж болно. Ашигт малтмалыг Нөөц рүү хувиргахад зарим буюу эсвэл бүх Нөлөөлөгч хүчин зүйлстэй холбоотой эргэлзээг анхааран тооцдог учир Мэргэшсэн этгээд нь Бодитой нөөцийг Магадлалтай нөөц рүү хөрвүүлж болно. Энэхүү харилцан уялдааг Зураг 1-д үзүүлээ. Тасарсан сумынчиглэл нь босоо компонентийг агуулж байгаа хэдий ч энэ жишээнд геологийн мэдлэг, үнэмшилт магадлалын түвшний бууралтыг харуулаагүй болно. Ийм нөхцөлд дээрх Нөлөөлөгч хүчин зүйлсэд бүрэн тайлбар өгвөл зохино.

33-р Бүлэгдэх зааврыг мөн харна уу.

ТАЙЛАН

13. Компаний Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцөд хамаатай Нийтэд тайлагнах тайланд эрдэсжилтийн төрөл, мөн чанарын тухай тодорхойлолтыг зайлшгүй багтаах ёстой.
14. Компани нь, ашигт малтмалын ордын эдийн засгийн үнэ өртөгт бодитоор нөлөөлж болохуйц тухайн ордтой холбоотой аливаа холбогдох мэдээллийг хавсаргах ёстой. Компани нь Ашигт малтмалын баялаг, ордын нөөцөд гарах аливаа материаллаг

өөрчлөлтйг даруйхан тайлагнах ёстой.

15. Компани нь Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийнхөө талаар ядаж жилд нэг удаа нягтлан шалгаж, нийтэд тайлагнах ёстой бөгөөд Ашигт малтмалын баялаг, ордын нөөц бүрийн хүчинтэй огноог харуулах ёстой. Компани нь Нийтэд тайлагнах тайландаа боломжийн хэрээр дэлгэрэнгүй мэдээлэл багтаах хэрэгтэй. Тухайн төсөл дэх Компаний эдийн засгийн сонирхлыг мэдүүлэх ёстой.
16. МТ Ангилалд зарим үг ерөнхий утгаар хэрэглэгддэг бол үйлдвэрлэлийн тодорхой салбарт олон тусгай утгатай байж болно. Ямар ч шаардлагагүй давхардлаас зайлсхийхийн тулд хавсралт 1-д ерөнхий нэр томъёог энэ баримт бичигт зорилгод ижил утгаар авч үзэж болох бусад нэр томъёоны хамт жагсаан үзүүлсэн болно.

Энэ баримт бичигт тусгай нэр томъёог ашиглахдаа энэ нь бүх нөхцөл байдалд онцгой буюу зайлшгүй гэж онцлон тэмдэглээгүй. Үүний нийтлэг жишээ гэвэл чулуу буюу бөөн чулууны тухай яригдаж байгаа үед уурхайн ажил нь карьерын буюу ил олборлолт хэлбэртэй байна. Мэргэшсэн этгээд нь тайлагнаж буй ажил буюу бүтээгдэхүүний хувьд хамгийн тохиромжтой нэр томъёог сонгож хэрэглэх шаардлагатай болно.

ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

17. Хайгуулын ажлын зорилт гэдэг нь тухайн ашигт малтмалын ордын хайгуулын ажлын нөөц чадамжийг геологийн тогтоосон нөхцөл байдалд таамаглах буюу тооцоолох үйл явц бөгөөд таамаг буюу тооцоог тонноор, мөн Ордын нөөцийн хайгуулын ажлыг хангалтгүй хэмжээнд хийсэн бол зэрэг буюу чанараар үнэлдэг.
18. Хайгуулын ажлын үр дүнд ашигт малтмалын хайгуулын ажлын хөтөлбөрийн хүрээнд цуглуулсан өгөгдөл, мэдээлэл орох ба үүнийг хөрөнгө оруулагч нар ашиглаж болох боловч Ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийн тухай мэдэгдэлд орохгүй.

Ийм байдал хайгуулын ажлын эхний шатанд нийтлэг тохиолдох бөгөөд цуглуулсан өгөгдлийн хэмжээ багтаамж буюу зэргээр тооцоолж үнэлэхэд ерөнхийдөө хангалтгүй байдаг. Үүний жишээ гэвэл ганц нэг илэрц, нэг өрөмдлөгийнгарц, эсвэл геофизикийн судалгааны үр дүн байна.

Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүн агуулж буй Нийтэд тайлагнах тайланд ийм мэдээллийг багтаамж буюу зэргээр тооцоолж үнэлэхэд тохиромжгүй гэдгийг тодорхой зааж өгвөл зохино. Ийм тайланд дараах өгүүлбэрээр байнгын тайлбар хийхийг зөвлөж байна.

"Энэхүү тайлан/тайлбар/мэдээн дэх мэдээлэл нь МТ Ангиллын 18-р зүйлийн дагуу тогтоосон Ашигт малтмалын хайгуулын ажлын үр дүнгээс бүрдэнэ. Ийм мэдээллийг багтаамж буюу зэргээр тооцоолж үнэлэхэд тохиромжгүй."

19. Хэрэв Компани нь Хайгуулын ажлын үр дүнг ашигт малтмал буюу Ордын нөөцөөр нь ангилж бус, харин эрдэсжилттэй нь холбон тайлагнаж буй бол багтаамжаар болон дундаж зэргээр тооцоолсон үнэлгээг тайлагнах ёсгүй.

Нийтэд тайлагнах тайланд өгөх хайгуулын ажлын зорилт буюу хайгуулын ажлын чадамжийн тухай тайлбарыг Ашигт малтмалын баялаг буюу ордын нөөцийн үнэлгээ мэтээр буруу ойлголт төрүүлэхгүйгээр илэрхийлбэл зохино.

20. Хайгуулын ажлын үр дүнг ашигт малтмал буюу Ордын нөөцөөр нь ангилж бус, харин эрдэсжилттэй нь холбосон Нийтэд тайлагнах тайланд, үр дүнгийн ач холбогдлыг тал талаас нь тэнцвэртэй шүүн дэнслэхэд хангалттай мэдээлэл оруулсан байх ёстой.

Хайгуулын ажлын үр дүнгийн тайланд үндэслэлгүйгээр эдийн засгийн ач холбогдолтой эрдэсжилт олдсон тухай бичих ёсгүй.

АШИГТ МАЛТМАЛЫН ТАЙЛАН

- 21. Ашигт малтмал гэдэг нь газрын царцдасын дотор буюу дээр үүссэн, зэрэг болон чанарын хувьд үйлдвэрлэлийн боломжит олборлолт явуулахад ирээдүйтэй төлөвтэй, эдийн засгийн ач холбогдол бүхий эрдсийн бөөгнөрөл буюу илэрц юм.**

Дээжлэлт болон геологийн баримт нотолгоо, мэдлэг дээр тулгуурлан Ашигт малтмалын байршил, тоо хэмжээ, зэрэг буюу чанар, үргэлжилсэн байдал, геологийн бусад шинж чанарын тухай мэдэж, үнэлгээ хийнэ.

Ашигт малтмалыг таамагласан, боломжтой, Бодитой категори дотор геологийн үнэмшилт магадлалын өсөх зарааллаар ангилж хуваадаг.

Тухайн Ашигт малтмалын ордын талбай дахь эдийн засгийн ач холбогдол бүхий олборлолт хийх боломжгүй хэсгийг Ашигт малтмалын нөөцөд оруулах ёсгүй.

Ашигт малтмалын баялгийг үнэлэхэд шаардлагатай геологийн баримт нотолгоо, мэдлэгт тухайн ашигт малтмалын орд илэрцийн геологи, хими, физик, эрдсийн найрлага шинжид тохирох зайтайгаар, боломжит, урьдчилан үнэлсэн, Бодитой нөөцийн бүх ангиллын хувьд хийсэн дээжлэлтийн өгөгдлийг багтаах ёстой. Дээжлэлтийн мэдээлэл байхгүй үед ашигт малтмалын нөөцийг тооцоолж болохгүй.

“Ашигт малтмал” гэдэг нэр томъёо нь Нөлөөлөгч хүчин зүйлсийг тооцож хэрэглэн Ордын нөөцийг тогтоосон хайгуул, дээжлэлтийн үед илрүүлж тооцоолсон овоолго, хаягдал болон эрдэсжилтийг хамардаг.

“Эдийн засгийн ач холбогдол бүхий олборлолт хийх боломж” гэдэг нэр томъёо нь эдийн засгийн олборлолтын хэтийн төлөвт, олборлолтын холбогдох параметрт нөлөөлж болохуйц техник эдийн засгийн хүчин зүйлстэй холбогдуулан Чадавхтай ажилтны хийж буй (урьдчилсан боловч) дүгнэлтийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, Ашигт малтмалын баялаг нь тухайн хэсгийн агуулгаас, магадгүй олборлох хэмжээ, байршил, үргэлжлэх байдлаас хамааралгүйгээр, өрөмдөж буюу дээжилж авсан бүх дээжийн бүртгэл биш юм. Энэ нь ул үндэслэлтэйгээр авчсан техник эдийн засгийн нөхцөлд бүхэлд нь буюу хэсэгчлэн авсан, эдийн засгийн хувьд баяжуулах боломжтой эрдсийн бүртгэл юм.

“Эдийн засгийн ач холбогдол бүхий олборлолт хийх боломж”-ийг тогтооход хийсэн аливаа материалын талаарх урьдчилсан төсөөллийг Нийтэд тайлагнах тайланд тодорхой тусгавал зохино.

Энэ бичвэр дэх “боломжит” (‘eventual’) гэдэг үг авч үзэж буй түүхий эд, эрдсээс хамааран хувьсаж болно. Жишээлбэл, зарим нүүрс, төмрийн хүдэр, боксит болон бусад бөөн эрдэс, түүхий эдийн хувьд “эдийн засгийн ач холбогдол бүхий олборлолт” нь 50-аас илүү жилийг хамарна хэмээн урьдчилан тооцоолж болохуйц байж болно. Гэхдээ, ихэнх алтны ордын хувьд энэ ойлголтыг магадгүй 10-15 жилээр, заримдаа түүнээс богино хугацаагаар хязгаарлан хэрэглэж болно.

Ордын нөөцийг үнэлэх зорилгоор цуглуулсан өгөгдөлд тухайлбал ордын захын агуулгаар ямар нэгэн зохицуулалт хийсэн бол Нийтэд тайлагнах тайланд тодорхой тайлбарлаж бичвэл зохино.

Зарим тайлан (жишээ нь, үнэлгээний тайлан, засгийн газарт өгөх хайгуулын ажлын тайлан, хөрөнгө оруулалтанд зориулан мэдээлэл өгөх зориулалтгүй бусад төстэй тайлан)-д эрдэсжилтийн талаарх бүхий л мэдээлэл, Эдийн засгийн боломжит олборлолтын хувьд хэтийн төлөв харуулаагүй материалыг ч тусгах шаардлага тавьж

болно. Эрдэсжилтийн талаарх ийм үнэлгээг МТ Ангиллын дагуу хийгдсэн Ашигт малтмалын баялаг, Ордын нөөц гэж баталж болохгүй.

22. Таамагласан ашигт малтмалын баялаг гэдэг нь тоо хэмжээ, зэрэг буюу чанарыг геологийн хязгаарлагдмал баримт нотолгоо, дээжлэлт дээр тулгуурлан тооцоолсон Ашигт малтмалын баялгийн тодорхой хэсэг юм.

Геологийн баримт нотолгоо нь геологийн, зэрэг буюу чанарын үргэлжлэх талбайг таамаглахад хангалттай боловч батлахад хангалтгүй.

Таамагласан ашигт малтмалын баялгийн хувьд үнэмшилт магадлал нь Боломжтой ашигт малтмалын баялагт ашиглагддагаас бага байх бөгөөд Ордын нөөц рүү хөрвүүлэх ёсгүй. Хайгуулын ажлыг үргэлжүүлснээр Таамагласан ашигт малтмалын ихэнх хэсгийг Боломжтой ашигт малтмалын баялагт шилжүүлж болно гэж найдах боломжтой.

Таамагласан гэдэг категор нь ашигт малтмалын баялгийн бөөгнөрөл буюу илэрц олдоод, бага хэмжээний дээжлэлт, хэмжил хийсэн боловч цуглуулсан өгөгдөл нь геологийн болон агуулгын үргэлжлэх талбайг үнэмшилтэйгээр тогтооход хангалтгүй байх нөхцөлийг хамардаг. Ер нь, хайгуулын ажлыг үргэлжүүлснээр Таамагласан ашигт малтмалын ихэнх хэсгийг Боломжтой ашигт малтмалд шилжүүлж болно гэж хүлээж болно. Гэхдээ, Таамагласан ашигт малтмал дахь эргэлзээний улмаас байнга ингэж шилжүүлж болно гэж үзэхгүй байвал зохино.

Нарийвчилсан төлөвлөлтөнд техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглахад үнэлгээний үнэмшил нь хангалттай бус байх болно. Энэ шалтгааны улмаас л Таамагласан ашигт малтмалын баялгийг Ордын нөөцийн аливаа категор руу шууд холбосон холболт байдаггүй юм (Зураг 1 үз).

Монгол улсын Ашигт малтмалын баялаг ба ордын нөөцийн ангиллыг МТ Ангиллын Таамагласан ашигт малтмалын баялгийн категор руу хөрвүүлэхэд “Монгол улсын Ашигт малтмалын баялгийг тайлагнах стандарттай уялдуулах заавар” болон МТ Ангиллыг харна уу.

Техник эдийн засгийн судалгаа хийхэд энэ категорыг авч үзэх гэж буй бол анхааралтай ажиллах хэрэгтэй.

23. Боломжтой ашигт малтмалын баялаг гэдэг нь тухайн ордын хувьд уурхайн төлөвлөлт, эдийн засгийн амьдрах чадварыг үнэлэхэд Нөлөөлөгч хүчин зүйлсийг хангалттай дэлгэрэнгүй хэрэглэх боломж олгохуйц хангалттай үнэмшилтэйгээр тоо хэмжээ, зэрэг буюу чанар, нягт, хэлбэр, физик шинж чанарыг нь тооцоолж буй Ашигт малтмалын баялгийн тодорхой нэг хэсэг юм.

Геологийн баримт нотолгоог холбогдох нарийвчилсан найдвартай хайгуул, дээжлэлт, шинжилгээнээс олж авах ба ажиглалтын цэгүүдийн хоорондох геологийн болон зэрэг, чанарын үргэлжлэх талбайг баримжаалахад хангалттай байдаг.

Боломжтой ашигт малтмалын баялаг нь Бодитой ашигт малтмалын баялагт хэрэглэдгээс арай бага үнэмшилт магадлалтай бөгөөд Магадалсан Ашигт малтмалын нөөц рүү л зөвхөн хувиргаж болно.

Боломжтой ашигт малтмалын баялагт хэрэглэдэг үнэмшлийн түвшин нь Бодитой ашигт малтмалын баялагт хэрэглэдгээс арай бага боловч Таамагласан ашигт малтмалынхаас их байдаг.

Өгөгдлийн мөн чанар, чанар, тоо хэмжээ, тархалт нь геологийн цар хүрээг

итгэлтэйгээр тайлбарлах, эрдэсжилтийн үргэлжлэх талбайг баримжаалахад ашиглагдаж буй үед тухайн эрдсийг Боломжтой ашигт малтмалын баялаг гэж ангилж болно.

Нарийвчилсан төлөвлөлтөнд техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглахад үнэлгээний үнэмшил нь хангалттай байх болно

Монгол улсын Ашигт малтмал ба нөөцийн ангиллыг МТ Ангиллын Таамагласан ашигт малтмалын категор руу хөрвүүлэхэд “Монгол улсын Ашигт малтмалын баялгийг тайлагнах стандарттай уялдуулах заавар” болон МТ Ангиллыг харна уу.

24. **Бодитой ашигт малтмал гэдэг нь тухайн ордын хувьд уурхайн төлөвлөлт, эдийн засгийн амьдрах чадварыг үнэлэхэд Нөлөөлөгч хүчин зүйлсийг хангалттай дэлгэрэнгүй хэрэглэх боломж олгохуйц хангалттай үнэмшилтэйгээр тоо хэмжээ, зэрэг буюу чанар, нягт, хэлбэр, физик шинж чанарыг нь тооцоолж буй Ашигт малтмалын тодорхой нэг хэсэг юм.**

Геологийн баримт нотолгоог холбогдох нарийвчилсан, итгэлүнэмшилтэй хайгуулын ажил, дээжлэлт, шинжилгээнээс олж авах ба ажиглалтын цэгүүдийн хоорондохь геологийн болон эрдсийн зэрэг, чанарын үргэлжлэх талбайг бататгахад хангалттай байдаг.

Бодитой ашигт малтмал нь Боломжтой болон Таамагласан ашигт малтмалын баялагт хэрэглэдгээс өндөр үнэмшилт магадлалтай. Үүнийг Ордын Баттай буюу Магадалсан нөөц рүү хувиргаж болно.

Мэргэшсэн этгээд өгөгдлийн мөн чанар, чанар, тоо хэмжээ, тархалтаар ашигт малтмалын эрдэсжилтийн багтаамж болон агуулгыг нарийн хязгаартайгаар, үнэлгээний аливаа хазайлт/зөрүү нь эдийн засгийн амьдрах чадварыг тооцоолоход мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байхаар ашигт малтмалыг тодорхойлоход ямар ч эргэлзээгүй байвал тухайн эрдэсжилтийг Бодитой ашигт малтмал гэж ангилж болно.

Энэхүү категорт ашигт малтмалын ордын геологи, хяналт нь өндөр үнэмшилт магадлал, ойлголттой байх шаардлагатай.

Тооцоон дахь үнэмшил нь техник эдийн засгийн параметрийг ашиглахыг хүлээн зөвшөөрөх, эдийн засгийн амьдрах чадварыг өндөр үнэмшилт магадлалтайгаар үнэлэхэд хангалттай байна.

Монгол улсын Ашигт малтмал ба нөөцийн ангиллыг МТ Ангиллын Таамагласан ашигт малтмалын категор руу хөрвүүлэхэд “Монгол улсын Ашигт малтмалын баялгийг тайлагнах стандарттай уялдуулах заавар” болон МТ Ангиллыг харна уу.

25. Ашигт малтмалын баялагт тохирох категорыг сонгох сонголт нь байгаа өгөгдлийн хэмжээ, тархалт, чанар болон тэдгээр өгөгдөлд хамаарах үнэмшилт магадлалаас хамаардаг. Тохирох категорыг Мэргэшсэн этгээд тогтоох ёстой.

Ашигт малтмалын баялгийн ангилал бол чадварлаг үнэлгээ дүгнэлтийн үндэс суурь болдог бөгөөд Мэргэшсэн этгээд нь Хүснэгт 1-д өгөгдсөн Ашигт малтмалын нөөцийн үнэлгээний үнэмшилд хамаатай зүйлсийг анхаарвал зохино.

Мэргэшсэн этгээд Бодитой болон Боломжтой ашигт малтмалын баялгийн алийг нь сонгох талаар шийдвэр гаргахад, 23 ба 24 дүгээр зүйл дэх геологийн болон агуулгын үргэлжлэх талбайд хамаатай хоёр тодорхойлолтоос гадна 24 дүгээр зүйл дэх Бодитой нөөцийн тодорхойлолтын тайлбар дахь “...үнэлгээний аливаа хазайлт/зөрүү нь эдийн засгийн амьдрах чадварыг тооцоолоход мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байх” өгүүлбэрийг

ач холбогдолтой гэж үзэж болно.

Мэргэшсэн этгээд Боломжтой болон Таамагласан ашигт малтмалын баялгийн алийг нь сонгох талаар шийдвэр гаргахад, 22 ба 23 дугаар зүйл дэх геологийн болон агуулгын үргэлжлэх талбайд хамаатай хоёр тодорхойлолтоос гадна 22 дугаар зүйлийн Таамагласан нөөцийн тодорхойлолт дахь “Тооцоон дахь үнэмшил нь нарийвчилсан төлөвлөлтөнд техник эдийн засгийн параметрийг ашигласан үр дүнг хүлээн зөвшөөрөхөд хангалттай бус байдаг.” болон “Техник эдийн засгийн судалгаа хийхэд энэ категорыг авч үзэх гэж буй бол анхааралтай ажиллах хэрэгтэй.” тайлбартай зөрчилддөг 23 дугаар зүйл дэх Боломжтой нөөцийн тодорхойлолт дахь “Тооцоон дахь үнэмшил нь нарийвчилсан төлөвлөлтөнд техник эдийн засгийн параметрийг ашигласан үр дүнг хүлээн зөвшөөрөхөд хангалттай байна.” тайлбарыг ач холбогдолтой гэж үзэж болно.

Геологийн болон агуулгын үргэлжлэх талбайг тооцоолж үнэлэх үедээ Мэргэшсэн этгээд нь эрдэсжилтийн төрөл, хэмжээсийн болон захын агуулгатай холбоотой баримтыг анхаарах хэрэгтэй.

26. Ашигт малтмалын үнэлгээ нь нарийн тооцоо биш бөгөөд тухайн илэрцийн байршил, хэлбэр, үргэлжлэх талбайн талаарх хязгаарлагдмал мэдээллийн тайлбар болон хийсэн дээжлэлтийн үр дүнгээс хамааралтай байдаг. Багтаамж болон зэргийг илэрхийлж буй тоог орон ахиулан хураангуйлах маягаар тооцооны харьцангуй эргэлзээг тооцох хэрэгтэй бөгөөд Таамагласан ашигт малтмалын баялгийн хувьд “ойролцоогоор” өөрчилнө.

Ихэнх нөхцөлд, хоёр дахь цифрт шилжүүлэх нь хангалттай байдаг. Тухайлбал, 8.23 хувийн 10,863,000 тонныг 8.2 хувийн 11 сая тонн гэж бичих нь зохистой. Гэхдээ, үнэлгээний эргэлзээг зөв илэрхийлэхийн тулд эхний цифрт шилжүүлэн хураангуйлах шаардлагатай байж болно. Үүнийг ихэвчлэн Таамагласан ашигт малтмалын баялагт хэрэглэх тохиолдол байдаг.

Ашигт малтмалын баялгийн үнэлгээний нарийвчлалтай бус мөн чанарыг тодруулахын тулд эцсийн үр дүнг тооцоо биш, ойролцоо үнэлгээ гэж үргэлж тайлбарлах нь зохистой.

Мэргэшсэн этгээд нь боломжтой бол ашигт малтмалын баялгийн үнэлгээний харьцангуй нарийвчлал болон үнэмшлийн талаар хэлэлцүүлэх хэрэгтэй. Тайлбарт энэ нь глобал (ашигт малтмал бүхэлдээ) юм уу эсвэл хэсэгчилсэн (нарийвчлал, үнэмшил нь нийт ашигт малтмалын баялгаас өөр байж болох ашигт малтмалын баялгийн хэсэг багц) үнэлгээнд хамаарахыг тодорхойлох ба хэрэв хэсэгчилсэн бол харгалзах багтаамж юм уу эзлэхүүнээр илэрхийлнэ. Харьцангуй нарийвчлал буюу үнэмшлийн талаар тайлбарлах боломжгүй бол эргэлзээний хувьд чанарын мэдээлэл өгвөл зохино (Хүснэгт 1-ээс хар).

27. Ашигт малтмалын Нийтэд тайлагнах тайланд “боломжит”, “урьдчилан үнэлсэн” болон “Бодитой ” категороос нэгийг буюу хэд хэдийг тогтоох ёстой. Категоруудыг нийлмэл байдлаар тайлагнах ёсгүй бөгөөд категор бүрийн нарийвчилсан мэдээллийг тус тусад нь өгнө. Ашигт малтмалын баялгийн тухайд агуулагдаж буй металл буюу эрдсийн агуулгаар тайлагнах ёсгүй, харин харгалзах багтаамж болон зэргээр үзүүлнэ. Ашигт малтмалын баялгийг Ордын нөөцтэй нэгтгэж болохгүй

МТ Ангиллаар өгөгдсөн категороос өөрөөр багтаамж болон зэргээр Нийтэд тайлагнахыг зөвшөөрөхгүй.

28. Хүснэгт 1-д, Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн тайлан боловсруулж буй үед анхаарвал зохих гол шалгууруудыг хураангуйлсан хэлбэрээр жагсаан үзүүлсэн. Эдгээр шалгуурын тухай Нийтэд тайлагнах тайланд хэлэлцүүлэх хэрэггүй бөгөөд эс бөгөөс Ашигт малтмалын үнэлгээ буюу ангилалд үлэмж нөлөөлдөг.

Нийтэд тайлагнаж буй үед Хүснэгт 1 дэх заалт бүрээр тайлбар өгөх шаардлагагүй, гэхдээ уншигчийн зүгээс ойлгоход буюу тайлагнасан үр дүн буюу үнэлгээний талаар боловсруулалт хийхэд үлэмж нөлөөлөхүйц аливаа асуудлыг хэлэлцүүлэх нь чухал. Хангалтгүй буюу эргэлзээтэй өгөгдөл, тухайлбал дээжийн металл авалт муу, лабораторийн шинжилгээний үр дүнгийн таарц муу, бөөн материалын нягтын талаарх мэдээлэл хангалтгүй байх гэх зэрэг нь хайгуулын ажлын үр дүн, эсвэл Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн үнэлгээг зарлахад найдвартай байдал буюу үнэмшилд муугаар нөлөөлж буй үед энэ нь маш чухал.

Юуг тайлагнах талаар эргэлзэж байвал хэт бага мэдээлэл оруулснаас хэт их мэдээлэл оруулж алдсан нь дээр.

Хүснэгт 1-д өгөгдсөн аливаа шалгуурт хамаарах, нөөцийг ихэсгэж буюу багасгаж мэдээлэхэд хүргэж болохуйц эргэлзээг ил тод бичих нь зохистой.

29. “Хүдэр”, “нөөц” гэдэг нэр томъёо нь техник эдийн засгийн үндэслэл, эдийн засгийн амьдрах чадварыг илэрхийлдэг бөгөөд өөрчлөгч бүх хүчин зүйлсийг анхааран үзсэн үед тохиромжтой тул эдгээр үгийг (“төмрийн хүдэр” гэх зэрэг нийтлэг хэрэглээний нөхцлөөс гадна) Ашигт малтмалын үнэлгээг тайлагнахад хэрэглэх ёсгүй. Техник эдийн засгийн үндэслэл, эдийн засгийн хувьд ач холбогдолтой байх хугацааг тогтоох хүртэл Тайлан, мэдэгдэлд тохирох категор буюу Ашигт малтмалын баялгийн категориос эш татаж явах нь зүйтэй. Хэрэв дахин үнэлгээгээр тухайн ордын аливаа хэсгийн нөөц нь цаашид амьдрах боломжгүй бол тийм нөөцийг Ашигт малтмалын баялаг гэж дахин ангилах буюу эсвэл Ашигт малтмалын баялаг/Нөөцийн мэдэгдлээс хасах ёстой.

Энэ нь, богино хугацаанд буюу түр зуурын шинж чанарын улмаас өөрчлөлт гарсны дүнд, эсвэл Компаний удирдлага эдийн засгийн үндэслэлгүйгээр ашиглах шийдвэр гаргасан үед Ордын нөөцөөс Ашигт малтмалын баялаг руу дахин ангилах, эсвэл эсрэг үйлдлийг хийвэл зохино гэсэн зүйл огт биш юм. Ийм нөхцөл байдлын жишээ гэвэл богино хугацаанд түүхий эдийн үнэ хэлбэлзэнэ гэж үзэх, тогтвортой бус мөн чанараас шалтгаалсан уурхайн онцгой нөхцөл байдал, тээвэрлэлтийн ажил хаялт гэх мэт юм.

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦИЙГ ТАЙЛАГНАХ

30. Ордын нөөц гэдэг нь Бодитой ба/буюу Боломжтой ашигт малтмалын баялгийн эдийн засгийн хувьд олборлох боломжтой нэг хэсэг юм.

Үүнд тухайн ордод олборлолт буюу боловсруулалт хийх үед гарч болох агуулга нь багассанбүтээгдэхүүн болон хорогдлын хувь хэмжээг багтаах бөгөөд Нөлөөлөгч хүчин зүйлсийг хэрэглэхэд тохиромжтой техник эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан буюу жинхэнэ судалгаагаар тогтоогдоно.

Тайлагнах үед ийм судалгаа нь олборлолт хийх боломжтой тухай нотолгоог харуулдаг.

Нөөцийг тодорхойлсон жишиг цэгийг заавал тогтоох ёстой бөгөөд энэ нь ихэвчлэн боловсруулахүйлдвэр рүү хүдэр оруулах цэг байна. Тайлагнасан бүх зүйлийг уншигчид бүрэн мэдээлэхийн тулд, жишиг цэг өөр өөр байх бүх нөхцөлд, тухайлбал арилжааны бүтээгдэхүүний хувьд тодотголыг тодорхой оруулсан байна.

Ордын нөөц гэдэг нь Мэргэшсэн этгээд өөрчлөгч болон олборлолтын бүх хүчин зүйл тооцон үнэлгээ тооцоо хийсний үндсэн дээр багтаамж болон зэргээр илэрхийлсэн, тодорхой хугацаанд эдийн засгийн хувьд ач холбогдолтой байх төслийн суурь тулгуур болж чадах Ашигт малтмалын баялгийн нэг хэсэг юм.

Ордын нөөцийг тайлагнахад үнэлж буй ашигт малтмалын баяжуулалтын металл

авалт маш чухал бөгөөд Нийтэд тайлагнах тайланд байнга оруулж байх хэрэгтэй.

“Эдийн засгийн хувьд олборлох боломжтой” гэдэг нэр томъёо нь санхүүгийн боломжит таамаглалын нөцхөлд Ордын нөөцийг боловсруулах ажил амьдрах чадвартай болохыг харуулж байна гэсэн утгатай. “Үндэслэлтэй нотлогдох” нэр томъёог бүрдүүлэгч нь ордын төрөл, хийгдсэн судалгааны түвшин, Компаний санхүүгийн шалгуураас хамааран өөрчлөгдөнө. Энэ учир шалтгааны улмаас “эдийн засгийн хувьд олборлох боломжтой” гэдэг нэр томъёонд тодорхой тогтоосон тодорхойлолт байхгүй байж болно. Гэхдээ, Компани нь оруулсан хөрөнгөн дээрээ ашиг олж авахаар чармайх ба тухайн төсөлд хөрөнгө оруулагчдад очих уг ашиг нь харьцуулах эрсдэл бүхий өөр бусад хөрөнгө оруулалттай өрсөлдөхүйц байна.

Ашигт малтмалын баялаг болон өөрчлөгч бүх хүчин зүйлийн хувьд шаардлагатай үнэмшилд магадлалд хүрэхийн тулд, техник эдийн засгийн үндэслэлийн аль тохирох урьдчилсан буюу жинхэнэ түвшний судалгааг Ордын нөөц тогтоохоос өмнө хийж гүйцэтгэнэ. Энэхүү судалгаа нь техникийн хувьд боломжтой, эдийн засгийн хувьд амьдрах чадвартай, ордын нөөцийг гарган авч болох олборлолтын төлөвлөгөөг тогтооно.

“Ордын нөөц” гэдэг нэр томъёо нь олборлох үйлдвэрлэл байгуулсан буюу ажиллаж байгаа, эсвэл бүх шаардлагатай баталгаа буюу худалдааны гэрээнүүд ирсэн гэдгийг харуулах шаардлагагүй юм. Энэ нь тийм баталгаа, гэрээг хийх боломжтой гэдгийг харуулж байгаа юм. Мэргэшсэн этгээд нь гуравдагч талаас хамааралтай, олборлолт хийх боломжтой аливаа шийдэгдээгүй асуудлын бодит мөн чанарыг анхааран үзвэл зохино.

Ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хийх зориулалттай өгөгдөлд жишээлбэл ордын захын агуулгаар хийж буй аливаа засварыг Нийтэд тайлагнах тайланд тодорхой бичиж тайлбарлавал зохино.

МТ Ангилал нь, олборлолт нь Ашигт малтмалын баялгийн Баттай нөөцтэй байна гэсэн утгыг илэрхийлдэггүй гэдгийг тэмдэглэх нь зохистой. Ордын Магадалсан нөөцөөр л зөвхөн олборлолт хийж болохыг нотлоход хангалттай байж болох, жишээ нь, тунамал цагаан тугалга, алмааз буюу алтны ордын хувьд нөхцөл байдал гарч ирж болно. Энэ нь Мэргэшсэн этгээдийн шийдвэрлэх хэрэг юм.

Хэрэв Ашигт малтмалын баялаг нь хуулинд нийцсэн тодорхойлолтын дагуу батлагдаагүй бол Монгол улсын хуулиар тухайн ордыг ашиглахыг хориглоно. Нөөцийг Улсын нөөцөд бүртгэж батлуулах нь эрх зүйн Нөлөөлөгч хүчин зүйл юм.

31. **Магадалсан ордын нөөц нь Урьдчилан үнэлсэн, зарим тохиолдолд Бодитой Ашигт малтмалын баялгийн эдийн засгийн хувьд олборлох боломжтой хэсэг юм.**

Магадалсан нөөцөд хэрэглэж буй Нөлөөлөгч хүчин зүйлийн үнэмшил нь Баттай нөөцийнхөөс бага байдаг.

Магадалсан нөөц нь Баттай нөөцийнхөөс бага үнэмшилт магадлалтай боловч тухайн ордыг ашиглах шийдвэр гаргахад хангалттай чанартай үндэслэл болно

Монгол улсын Ашигт малтмалын баялаг ба нөөцийн ангиллыг МТ Ангиллын Магадалсан ашигт малтмалын категор руу хөрвүүлэхэд “Монгол улсын Ашигт малтмал тайлагнах стандарттай уялдуулах заавар” болон МТ Ангиллыг харна уу.

32. **Баттай Ордын нөөц нь Бодитой Ашигт малтмалын баялгийн эдийн засгийн хувьд олборлох боломжтой хэсэг юм. Баттай Ашигт малтмалын баялаг нь Нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд өндөр үнэмшилт магадлал илэрхийлдэг.**

Баттай нөөц нь нөөцийн үнэлгээний хувьд хамгийн өндөр үнэмшилт магадлалыг харуулдаг.

Эрдэсжилтийн төрөл бусад хүчин зүйл нь зарим ордын хувьд Баттай Ордын нөөцийг гүйцэд авах боломжгүй гэсэн утгатай байж болно. Мэргэшсэн этгээд, холбогдох бүх нөөцийн параметр болон Нөлөөлөгч хүчин зүйлсийг ойролцоо өндөр үнэмшилт магадлалтайгаар тогтоосныг бататгахаасаа өмнө уг материалыг өндөр үнэмшилт магадлалтай гэж мэдээдэхийн үр дагаврыг мэдэж байвал зохино.

Монгол улсын Ашигт малтмалын баялаг ба нөөцийн ангиллыг МТ Ангиллын Баттай ашигт малтмалын баялагийн категор руу хөрвүүлэхэд “Монгол улсын Ашигт малтмал тайлагнах стандарттай уялдуулах заавар” болон МТ Ангиллыг харна уу.

33. Ордын нөөцийн тохирох категорыг сонгохдоо Нөлөөлөгч хүчин зүйлс дэх аливаа эргэлзээг анхааран үзсэний дараа тухайн Ашигт малтмалын баялгийн үнэмшлийн түвшингээр тогтооно. Тохирох категор сонгох ажлыг Мэргэшсэн этгээд хийх ёстой.

МТ Ангилал нь Боломжтой болон Магадалсан нөөцийн хоорондох, мөн Бодитой болон Баттай нөөцийн хоорондох шууд холбоо хамаарлыг үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, Магадалсан нөөцийн геологийн үнэмшилт магадлал нь Боломжтой нөөцийг тодорхойлоход тавигдсан шаардлагатай ойролцоо юм. Баттай нөөцийн геологийн үнэмшилт магадлал нь Бодитой нөөцийг тодорхойлоход тавигдсан шаардлагатай ойролцоо байна. Боломжтой нөөц нь Ашигт малтмалын баялагт байнга нэмэгдэж байдаг.

МТ Ангилал нь бас Бодитой болон Магадалсан нөөцийн хоорондох хоёр замт холбоо хамаарлыг харуулдаг. Энэ нь, Ашигт малтмалын баялгийн нөөцийн үнэмшил нь харгалзах Ашигт малтмалын баялаг дахиад бага байх үед Ашигт малтмалын баялгийг Нөөц рүү шилжүүлэхэд аливаа Нөлөөлөгч хүчин зүйлтэй холбоотой эргэлзээг анхааран үзэх нөхцөлийг хамарна. Ийм шилжүүлэлтэнд геологийн мэдлэгийн түвшин буюу үнэмшил бага гэдгийг илэрхийлэхгүй.

Нөлөөлөгч хүчин зүйлсийн эргэлзээг арилгасан бол Бодитой нөөцөөс гаргаж авсан Магадалсан нөөцийг Баттай нөөц рүү шилжүүлж болно. Ашигт малтмалын баялгаас нөөц рүү шилжүүлэхэд Нөлөөлөгч хүчин зүйлсийн үнэмшлийн хэмжээ байхгүй бол Ашигт малтмалын баялагт байгаа үнэмшлийн дээд хязгаарыг анхаарахгүй байж болно. Ямар ч нөхцөлд Боломжтой Ашигт малтмалын баялгийг Баттай нөөц рүү шууд шилжүүлж болохгүй (Зураг 1 үз).

Баттай ордын нөөцийн категорыг хэрэглэх нь хамгийн сайн үнэмшлийн түвшинтэй тооцоо хийсэн болохыг илэрхийлэх бөгөөд тухайн тайланг уншигчдын санаанд хүлээлт үүсгэнэ. Ашигт малтмалын баялгийг Бодитой категорт оруулах үед энэ хүлээлт санагдах болно.

Ашигт малтмалын ангиллын талаар 25 дугаар зүйлээс харна уу.

34. Ордын нөөцийн үнэлгээ нь нарийвчилсан тооцоо биш юм. Багтаамж болон зэргийг тоогоор тайлагнахад тоог ойролцоогоор хураангуйлснаар үнэлгээний харьцангуй эргэлзээг харуулна. 26 дугаар зүйлээс бас харна уу.
Ордын нөөцийн тооцооны нарийвчлалтай бус мөн чанарыг харуулахын тулд эцсийн дүнг тооцоо бус, ойролцоогоор тооцоолсон тооцоо гэж бичиж байх хэрэгтэй.

Боломжтой бол Мэргэшсэн этгээд нь ордын нөөцийн тооцоон дахь харьцангуй нарийвчлал болон үнэмшлийг тогтоож хэлэлцүүлэх хэрэгтэй. Энэ нь глобал (Ашигт малтмалын баялаг бүхэлдээ) юм уу эсвэл хэсэгчилсэн (нарийвчлал, үнэмшил нь нийт ашигт малтмалын баялагаас өөр байж болох ашигт малтмалын баялгийн хэсэг багц) үнэлгээнд хамаатай эсэхийг тогтоож, хэрэв хэсэгчилсэн бол багтаамж буюу эзэлхүүнээр хийлэрхийлнэ.

Харьцангуй нарийвчлал болон үнэмшлийг тогтоох боломжгүй бол эргэлзээний чанарын утгын талар хэлэлцүүлбэл зохино (Хүснэгт 1 болон 26 дугаар зүйл дэх тайлбараас харна уу).

35. Ордын нөөцийн нийтэд тайлагнах тайланд “Батлагдсан” болон “Магадлалт” категорын нэгийг буюу хоёуланг тайлбарлаж тодорхойлох ёстой. Категорын тухайд Магадалсан болон Баттай нөөцийн категорыг нийлүүлэн тайлагнаж болохгүй, харин категори бүрд холбогдох тоо өгөх хэрэгтэй. Тайланд металл буюу эрдсийн агуулгын тоог үзүүлэх ёсгүй, харин багтаамж болон зэргийг тоогоор өгнө. Ордын нөөцийг Ашигт малтмалын баялагтай нийлүүлэх ёсгүй.

МТ Ангиллаар өгөгдсөн категороос өөрөөр багтаамж болон зэргээр Нийтэд тайлагнахыг зөвшөөрөхгүй.

Ордын нөөцөд анхдагч Ашигт малтмалын баялагт хамааралгүй материал (дагалдагч бүтээгдэхүүн)-тай нийлүүлж болно. Хэрэв энэ хоёроос харьцуулалт хийх гэж байгаа бол Ашигт малтмалын баялаг болон Ордын нөөцийн хоорондох үндсэн ялгааг анхааралдаа авах хэрэгтэй.

Ордын нөөц болон Ашигт малтмалын баялгийн талаарх мэдэгдэлд өөрчлөлт оруулаад нийтэд тайлагнасан бол өмнөх мэдэгдлийг хамт хавсаргах хэрэгтэй. Тоонуудын хоорондох зөрүүний дэлгэрэнгүй тайлан тийм чухал биш, харин уншигчдад ойлгомжтой байлгахын тулд мэдэгдэхүйц өөрчлөлтийн талаар хангалтаар тайлбар хийвэл зохино.

36. Ашигт малтмалын баялаг болон ордын нөөцийн хоёулангийнх нь тоог тайлагнаж буй нөхцөлд, тухайн Ашигт малтмалын баялаг нь Ордын нөөцөд багтаж байгаа юу эсвэл нэмэгдэж байгаа юу гэдэг талаар тодорхой заасан мэдэгдлийг тайланд тусгах ёстой.

Ордын нөөцийн үнэлгээг Ашигт малтмалын баялгийн үнэлгээнд нэмж, нийлмэл нэг тоо тайлагнах ёсгүй.

Зарим нөхцөлд Ашигт малтмалын баялгийг Ордын нөөцөд багтаан тайлагнах учир шалтгаан байдаг бол бусад нөхцөлд Ашигт малтмалын баялгийг Ордын нөөцөд нэмж тайлагнах учир шалтгаан байна. Ямар хэлбэрээр тайлагнаж байгаагаа тодорхой болгох ёстой.

“Бодитой болон Боломжтой Ашигт малтмалын баялаг нь Ордын нөөц болгон өөрчилсөн Ашигт малтмалын баялагт багтана.”

эсвэл

“Бодитой болон Боломжтой Ашигт малтмалын баялаг нь Ордын нөөцөд нэмэгдэнэ.”

Өмнөх тохиолдолд, эдийн болон бусад шалтгаанаар Бодитой болон Боломжтой Ашигт малтмалын баялгийг Ордын нөөц болгон хувиргаагүй бол ингэж өөрчлөөгүй Ашигт малтмалын баялгийн талаар холбогдох мэдээллийг тайланд оруулбал зохино. Энэ нь тайланг уншигчдад өөрчлөөгүй Бодитой болон Боломжтой Ашигт малтмалын баялгийг эцэст нь Ордын нөөц болгон хувиргах боломжтой талаар шүүн тунгаахад тусална.

Боломжтой Ашигт малтмалын баялаг нь тодорхойлолт ёсоор Ордын нөөцөд байнга нэмэгддэг.

33 дугаар зүйл дэх тайлбарт болон энэ 33 дугаар бүлэгт бичсэн шалтгааны улмаас Ашигт малтмалын баялгийн тайлагнасан тоог Ордын нөөцийн тайлагнасан тоонд нэмэх ёсгүй. Гарсан нийлбэр нь төөрөгдөлд оруулан, буруу ойлгогдох буюу Компаний

ирээдүйн төлөвт хуурамч төсөөлөл өгөхүйцээр буруу ашиглагдах болно.

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА

37. Хамрах хүрээний судалгаа нь Ашигт малтмалын баялгийн эдийн засгийн хувьд ач холбогдолтой үргэлжлэх хугацааг тогтоох техник эдийн засгийн чухал судалгааны захиалга бөгөөд тайлагнах үед тайлбарлаж болох урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийн явцыг харуулахад шаадлагатай Нөлөөлөгч хүчин зүйлс болон аливаа бусад холбогдох ажлын хүчин зүйлсийг бодитойгоор анхааран хийсэн харгалзах үнэлгээг хамарна.
38. Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл нь олборлох аргын, тухайлбал газар доорх буюу гүний уурхайн тохиолдолд, эсвэл ил уурхайн тохиолдолд аль тохиромжтойг нь сонгох шатанд хүрсэн, Ашигт малтмалын баялгийн боловсруулалтын үр ашигтай аргыг нь тогтоосон Ашигт малтмалын баялгийн төслийн техник эдийн засгийн амьдрах чадварыг өргөн сонголтын хүрээнд нарийвчлан судалж буй судалгаа юм. Үүнд, Нөлөөлөгч хүчин зүйлсийн боломжит таамаглалд тулгуурласан санхүүгийн шинжилгээ болон Чадавхтай ажилтны зүгээс тайлагнах мөчид баялгийн бүх буюу зарим хэсгийг Ордын нөөцөд хувиргаж болох эсэхийг тогтооход хангалттай, холбогдох бусад хүчин зүйлс багтдаг. Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийн үнэмшлийн түвшин нь техник эдийн засгийн үндэслэлийнхээс бага байна.
39. Техник эдийн засгийн үндэслэл нь тухайн Ашигт малтмалын баялгийн төслийн хувьд сонгосон боловсруулалтын аргын техник эдийн засгийн нарийвчилсан судалгаа бөгөөд ашиглах боломжтой Нөлөөлөгч хүчин зүйлс болон бусад холбогдох ажлын хүчин зүйлсийн дэлгэрэнгүй үнэлгээ, мөн тайлагнах мөчид олборлолт явуулах нь боломжтой (эдийн засгийн хувьд олборлох боломжтой)-г нотлоход шаардлагатай санхүүгийн нарийвчилсан шинжилгээг багтаана. Энэхүү судалгааны үр дүн нь төслийн ажлыг үргэлжлүүлэх буюу санхүүжүүлэхийн тулд хэрэгжүүлэгч буюу санхүүгийн байгууллагаас эцсийн шийдвэр гаргах үндэслэл болох боломжтой. Энэ судалгааны үнэмшилт магадлал нь Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийнхээс өндөр байдаг.
40. Хүснэгт 1-д, Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмал, Ордын нөөцийн тайлан боловсруулж буй үед анхаарвал зохих гол шалгууруудыг хураангуйлсан хэлбэрээр жагсаан үзүүлсэн. Эдгээр шалгуурын тухай Нийтэд тайлагнах тайланд тусгах шаардлагагүй бөгөөд эс бөгөөс Ашигт малтмалын баялгийн үнэлгээ буюу ангилалд үлэмж нөлөөлдөг. Эдийн засгийн болон улс төрийн хүчин зүйлс дэх өөрчлөлт нь Ордын нөөцөд мэдэгдэм өөрчлөлт оруулах үндэс болж болох бөгөөд тиймээс тайлагнавал зохино.

ЭРДЭСЖСЭН ДАЛАН, БАГАНА, БАГА ЗЭРГИЙН ЭРДЭСЖИЛТ, ХҮДРИЙН ОВООЛГО, ОВООЛГО БОЛОН ХАЯГДЛЫГ ТАЙЛАГНАХ

41. МТ Ангиллыг эдийн засгийн ач холбогдол бүхий бүх төрлийн эрдсийн түүхий эдэд ашигладаг. Үүнд эрдэс бүхий далан, үлдэгдэл, багана, бага агуулгатай илэрц, хүдрийн овоолго, овоолго болон хаягдал (үлдэгдэл материал) орж болох ба Ашигт малтмалын баялаг гэж үзэх тохиолдолд олборлолт хийх боломжтой байна. Өөрөөр заагаагүй бол МТ Ангиллын бусад бүх зүйлийг (зураг 1-ийг оролцуулан) хэрэглэнэ.

Ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийг тайлагнахын тулд энэ зүйлд тодорхойлсон аливаа эрдсийн түүхий эдийг газар дээрх эрдэсжилттэй төсөөтэй гэж авч үзэж болно.

Ийм эрдсийн түүхий эдийн олборлох боломжийн талаарх нотолгоог холбогдох дадлага туршлага бүхий, Мэргэшсэн этгээдээр цохогдсон мэргэжлийн хүн хийвэл зохино.

Энэ зүйлд тодорхойлсон эрдсийн түүхий эд бүхэлдээ буюу зарим хэсэг нь эдийн засгийн боловсруулалт хийх хэтийн боломжгүй бол уг материалыг Ашигт малтмалын баялаг буюу эсвэл Ордын нөөц хэмээн ангилж болохгүй. Хэрэв тухайн материалын зарим хэсэг нь эдийн засгийн багахан ач холбогдолтой, гэхдээ олборлолт нь эдийн засгийн ач холбогдолтой бол энэ материалыг Ашигт малтмалын баялаг гэж ангилж болно. Хэрэв техник эдийн засгийн үндэслэлээр бодитой тогтоосон нөхцөлд эдийн засгийн олборлолт хийх боломжтойг харуулж байвал тухайн материалыг Ордын нөөц гэж ангилж болно.

Дээрх тайлбарыг газар дээрх бага зэргийн эрдэсжилтэнд адилхан хэрэглэж болох ба заримдаа “эрдэс бүхий хаягдал” буюу “бага агуулгатай материал” гэж авдаг бөгөөд уурхайг хаах үед үүссэн хүдрийн овоолго, боловсруулалтанд бас хэрэглэнэ. Ойлголтыг тодорхой болгохын тулд, ийм материалын багтаамж болон зэргийн үнэлгээг Ашигт малтмалын баялаг болон Ордын нөөцийн нийт тоонд нийлүүлж болох хэдий ч энэ үнэлгээг Нийтэд тайлагнах тайланд тусад нь зүйлчлэн оруулна.

Хүдрийн овоолгыг тогтоохдоо гадаргуу дээрх болон газар доорх овоолгыг хоёуланг мөргөцөгийн налуу дахь эвдэрсэн хүдрийн хамт оруулах бөгөөд мөн хүдэр хадгалах систем доторх хүдрийг бас оруулж болно. Боловсруулалтанд (уусгалт) орж буй эрдэс бүхий материалыг тайлагнаж байгаа бол тусад нь тайлагнавал зохино.

НҮҮРСНИЙ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН, АШИГТ МАЛТМАЛ БОЛОН НӨӨЦИЙГ ТАЙЛАГНАХ

42. МТ Ангиллын 42-44 дүгээр зүйлд Нүүрсний хайгуулын ажлын үр дүн, нүүрсний ашигт малтмалболон нөөцийг Нийтэд тайлагнахтай холбоотой асуудлыг тусад нь тусган үзүүлнэ. Өөрөөр заагаагүй бол энэхүү МТ Ангиллын 1-41 дүгээр зүйл (Зураг 1-ийг оруулан)-ийг хэрэглэнэ. Тайлбарын нэг хэсэг болох зураг 1-ийг Нүүрсний Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн талаар тайлагнахад итгэлтэйгээр анхаарах хэрэгтэй.

Нийтэд тайлагнах зориулалтаар, нүүрсэнд тавигдах шаардлага нь бусад түүхий эдийнхтэй ерөнхийдөө ойролцоо бөгөөд “эрдэс/ашигт малтмал”-ыг “нүүрс”-ээр, “зэрэг”-ийг “чанар”-аар солино.

43. “Ашигт малтмалын баялаг” болон “Ордын нөөц” гэдэг нэр томъёо, эдгээрийн дээр тодорхойлсон салбар хэсгийг мөн нүүрсний тайланд хэрэглэх боловч нь тайлагнагч Компани “Нүүрсний Ашигт малтмал”, “Нүүрсний нөөц” гэдэг нэр томъёо, бусад тохирох салбар хэсгээр орлуулж болно.
44. Бохирдолт гэх зэрэг олборлолтын хүчин зүйлээс гадна боловсруулалтаас үүдэх өөрчлөлтийг анхааран үзсэн үед баяжуулсан буюу сайжруулсан нүүрсний бүтээгдэхүүнийг илэрхийлж буй “Товарын нүүрсний нөөц”-ийг Нүүрсний нөөцийн тайлангийн оронд бус, түүнтэй хамт нийтэд тайлагнаж болно. Товарын нүүрсний нөөцөд хүргэх таамаг гарцын суурь үндсийг бичвэл зохино.

АЛМААЗ БОЛОН БУСАД ҮНЭТ ЧУЛУУНЫ ХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН, АШИГТ МАЛТМАЛ, ОРДЫН НӨӨЦИЙГ ТАЙЛАГНАХ

45. МТ Ангиллын 45-48 дугаар зүйлд тусгайлан алмааз болон үнэт чулууны Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийг нийтэд тайлагнахтай холбоотой асуудалд чиглэдэг. Өөрөөр заагаагүй бол энэхүү МТ Ангиллын 1-41 дүгээр зүйл (Зураг 1-ийг оруулан)-ийг хэрэглэнэ. Алмааз болон үнэт чулууны Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийг тайлагнахдаа зааврын салшгүй хэсэг болох Хүснэгт 1-ийг зайлшгүй анхаарвал зохино.

Нийтэд тайлагнах зориулалтаар, алмааз болон үнэт чулуунд тавигдах шаардлага нь бусад түүхий эдийнхтэй ерөнхийдөө ойролцоо бөгөөд “эрдэс/ашигт малтмал”-ыг “алмааз”-аар, “зэрэг”-ийг “зэрэг болон алмаазны дундаж хэмжээ”-ээр солино. Алмаазны ордод шал өөр утга илэрхийлдэг тул “чанар”-ыг “зэрэг”-ээр сольж болохгүй.

Алмаазын орд нь бусад төрлийн, тухайлбал ердийн төмөрлөгийн болон нүүрсний ордоос өөр, хэд хэдэн онцлог шинж чанартай байдаг бөгөөд онцгой анхаарал шаарддаг. Үүнд, эрдсийн бага агуулга, үндсэн болон шороон ордууд дахь хувьсамтгай байдал, алмаазын мөхлөгийн шинж чанар, алмаазын үнэлгээнд тавигдах тусгай шаардлага болон алмаазын нөөцийн тооцоо хийхэд тулгаргах угийн бэрхшээл, эргэлзээ зэрэг орно.

46. Дээжлэлтэд тулгуурласан алмаазын тайланд ямар үндэслэлээр дээжлэлт хийсэн тухай мэдээлэл, гаргаж авах арга, алмааз авалтын тухай материалыг өгөх ёстой. Алмааз нь худалдах боломжгүй хэт жижиг гэж үзвэл гаргаж авсан алмаазын жинг тайланд оруулахгүй байж болно. Энэхүү хязгаарын доод хэмжээг тэмдэглэвэл зохино.

Чулууны ширхэглэгийн тархалт, алмааз болон бусад үнэт чулууны үнэ нь Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн үнэлгээнд шийдвэрлэгч зүйлс юм. Хайгуулын ажлын эхний шатанд дээжлэлт болон зураглалын өрөмдлөгөөр ер нь энэ мэдээллийг авахгүй, харин том диаметртай өрөмдлөг, ялангуяа бөөн дээжлэлтээс авна.

Тухайн ашигт малтмалын баялгийн хувьд эдийн засгийн боломжит олборлолт явуулах хэтийн төлөвтэйг харуулахын тулд, чулууны ширхэглэгийн тархалт болон үнийн талаар урьдчилсан байдлаар ч гэсэн бодитой үнэлэмж өгөх хэрэгтэй. Энгийн, нэг биет буюу нэг фазын ордуудад Таамагласан ашигт малтмалын баялгийг тогтооход тийм мэдээллийг төлөөлөхүйц том диаметртай өрөмдлөгөөс гарган авч болно. Зарим хэлбэрийн бөөн дээжлэлт, тухайлбал цэглэн болон канавын аргаар ихэвчлэн их хэмжээний дээж авч болно.

Боломжтой нөөцийг тогтоох, үүнээсээ Магадалсан нөөц рүү хөрвүүлэхийн тулд чулууны ширхэглэгийн тархалт болон хэмжээг бүхэлд нь тогтооход хэрэгтэй илүү их хэмжээний бөөн дээж авах нь зүйтэй. Ер нь, үнийг баталгаатай тооцоолоход хангалттай хэмжээний алмааз авахад тохируулсан газар доорх боловсруулалтаар тийм хэмжээний бөөн дээжийг авна.

Нийлмэл ордын хувьд авсан бөөн дээж нь тухайн ордыг бүхэлд нь төлөөлнө гэдэгт баталгаа өгөхөд хэцүү байж болно. Шууд бөөн дээж авалт, ширхэглэгийн хэмжээний өргөн уудамд үргэлжлэх байдал болон үнийн харилцан уялдааг харуулахад гарах эргэлзээ зэрэг нь холбогдох Ашигт малтмалын баялгийн категорыг тогтооход үнэмшилтэй байвал зохино.

47. Алмаазын ашигт малтмал буюу Алмаазын нөөцийн зэрэг (карат/тонн)-ийг маш жижиг ширхэгтэй (микро) алмаазын тааралдах давтамж болон чулууны худалдах хэмжээний хоорондох хамаарал дээр үндэслэн тогтоосон бол үүнийг мэдэгдэх ёстой, тухайн аргачлалын найдвартай байдлыг тайлбарлаж, тайланд тусгасан микро алмаазын шигшүүрын хязгаарын хэмжээг заавал бичих ёстой.

48. Алмааз болон бусад үнэт чулууны эрдэсжилтийн талаар Нийтэд тайлагнах тайланд, аливаа тайлагнаж буй алмааз буюу үнэт чулууны нэг багцын үнэ өртөг нь хараат бус болохыг бататгасан тайбар мэдээлэлтэй хамт оруулах шаардлага байдаг. Тус үнэ өртөг нь нэр хүндтэй, мэргэшсэн мэргэжилтний боловсруулсан тайланд үндэслэх ёстой.

Хэрэв нэг багц алмаазын үнэ өртгийг тайлагнаж буй бол агуулагдаж буй алмаазын каратаар өгөгдсөн жин, доод хязгаарын хэмжээг зааж өгөх ёстой ба алмаазын үнийг карат бүрд америк доллараар өгөх ёстой. Алмаазын баялаг буюу Алмаазын нөөцийг үнэлж тооцоолоход үнэ өртөг хэрэглэж буй бол тухайн орд дахь алмаазын ширхэглэгийн хэмжээ, хэлбэр, өнгөний тархалтыг төлөөлөхүйц боодолд тулгуурлан уг үнэ өртгийг тооцох ёстой.

Бүхэлд нь ангижруулах аргаар боловсруулсан алмаазын дээжинд алмаазын үнэ өртгийг тайлагнахгүй.

Хүснэгт 1-д, Алмааз болон бусад үнэт чулууны Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмал, Ордын нөөцийн тайлан боловсруулж буй үед анхаарвал зохих гол шалгууруудыг хураангуйлсан хэлбэрээр жагсаан үзүүлсэн.

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭРДСИЙН ТҮҮХИЙ ЭДИЙНХАЙГУУЛЫН АЖЛЫН ҮР ДҮН, АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЛАГ, ОРДЫН НӨӨЦИЙГ ТАЙЛАГНАХ

49. МТ Ангиллын 49-50 дугаар зүйл нь түүхий эдийн техник үзүүлэлт, худалдаалах баталгаанд үндэслэн худалдан борлуулдаг Үйлдвэрлэлийн эрдсийн түүхий эд, чулуу, бүх хэлбэрийн бөөн чулуу, мөн борат, тальк, каолин зэрэг бусад их хэмжээний бараа гэх мэтийн талаар нийтэд тайлагнах тайланд чиглэнэ. Өөрөөр заагаагүй бол энэхүү МТ Ангиллын 1-41 дүгээр зүйл (Зураг 1-ийг оруулан)-ийг хэрэглэнэ. Үйлдвэрлэлийн эрдсийн Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийг тайлагнахдаа зааврын салшгүй хэсэг болох Хүснэгт 1-ийг зайлшгүй анхаарвал зохино.

Үйлдвэрлэлийн эрдсийн түүхий эдийн мэдээлэл, ойролцоо үнэлгээг тайлагнахдаа МТ Ангиллын гол зарчим, зориулалтыг ашиглаж, анхаарч байвал зохино. Заримдаа шинжилгээ тохиромжгүй байж болно, чанарын бусад шалгуурыг хэрэглэх нь илүү зохистой байж болно. Хэрэв хортой эрдэс буюу физик шинж чанар гэх мэт шалгуур бөөн эрдсийн найрлагыг тогтоохоос илүү тохиромжтой бол түүнийг л тайлагнах хэрэгтэй.

Үйлдвэрлэлийн эрдсийн түүхий эдийн баялаг, Ордын нөөцийг үнэлэхэд тулгуурлах хүчин зүйлс нь МТ Ангилалд хамрагдаж буй бусад төрлийн ордынхтой ижил байдаг. Ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийг тайлагнахын өмнө бүтээгдэхүүний техник үзүүлэлт, зах зээлд ойрхон байдал, бүтээгдэхүүний худалдагдах боломж гэх зэрэг зарим гол онцлог шинжийг тухайлан анхаарах хэрэгтэй байж болно

Зарим үйлдвэрлэлийн эрдсийн түүхий эдийн хувьд Ордын нөөц гэж үздэг “олборлосон” бүтээгдэхүүнээс илүү борлуулагдах бүтээгдэхүүний талаар тайлагнах нь нийтлэг байдаг. Борлуулагдах бүтээгдэхүүний тухай тайлагнаж буй бол үүнийг Ордын нөөцийн оронд бус, түүнтэй хамт тайлагнах нь зүйтэй бөгөөд энэ нь МТ Ангилалд илүүтэйд үздэг аргачлал юм. Гэхдээ, худалдан борлуулалтын мэдрэг чанар нь тайлангийн энэхүү хэлбэрийг үргэлж зөвшөөрөхгүй байж болно. Борлуулагдах бүтээгдэхүүнийг тайлагнаж буй бүх нөхцөлд юуны тухай тайлагнаж буй талаар уншигчдад бүрэн мэдээлэхийн тулд тодруулга мэдээллийг оруулах нь маш чухал.

Зарим үйлдвэрлэлийн эрдсийн түүхий эдийн орд нь хэд хэдэн хэрэглээ буюу техник үзүүлэлтэнд тохирох бүтээгдэхүүн гаргах боломжтой байж болно. Хэрэв тухайн материалыг тайлагнагч Компани анхаарч байгаа бол ийм олон төрлийн бүтээгдэхүүнийг тус тусад нь буюу эсвэл том ордод эзлэх хувиар тоо хэмжээг нь тодорхойлбол зохино

50. Нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд, үйлдвэрлэлийн эрдсийн түүхий эд, чулуу, бөөн чулуунд ердийн геологийн үзүүлэлтүүд нэг их ач холбогдолгүй байж болно. Чанар болон арилжаалагдах чадвар гэх мэт хүчин зүйлс нь чухал бөгөөд Ордын нөөцийг мэдэгдэхээс өмнө анхааралтай авч үзвэл зохино.

УЛАМЖЛАЛТ БУС ЭРЧИМ ХҮЧНИЙ АШИГТ МАЛТМАЛЫГ ТАЙЛАГНАХ

51. “Уламжлалт бус эрчим хүчний” ашигт малтмал нь хатуу ашигт малтмал бол Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, Ордын нөөцөд МТ Ангиллыг ашиглана.

МЕТАЛЛ ЭКВИВАЛЕНТЫГ ТАЙЛАГНАХ

52. Полиметаллын ордын Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал, Ордын нөөцийг металл эквивалент (үндсэн нэг металлын эквивалент зэрэг)-аар тайлагнахад бүрэлдэхүүн хэсэг бүрийн цэвэр үнэд нэмэгдэх материалын бүх хүчин зүйлийг нарийвчлан үзүүлэх ёстой.

3 дугаар зүйлд заасан, Ил тод, бодит, материаллаг байдлын зарчмыг батлахын тулд металл эквивалентыг оруулсан дараах мэдээллийг ядаж аливаа Нийтэд тайлагнах тайланд хавсаргах ёстой. Үүнд:

- металл эквивалентын тооцоонд орсон, бүх металлын тус тусын зэрэг,
- бүх металлд тооцоолсон барааны үнэ,
- бүх металлд тооцоолсон металл авалт, уг металл авалтыг гарган авсан үндэс суурь,
- металл эквивалентын тооцоонд орсон бүх элемент нь авагдах, худалдах боломжтой гэдэг нь Компаний үзэл бодол болох тухай тодорхой мэдэгдэл,
- ашигласан тооцооны томъёо.

Ихэнх нөхцөлд, эквивалент болгон сонгосон металл нь металл эквивалентын үнийн ихэнх хувийг эзлэх хэрэгтэй. Хэрэв ийм биш бол, өөр металлыг сонгох болсон шалтгааныг тодорхой тайлбарлаж тайланд оруулах ёстой.

Металл бүрийн металл авалтын ойролцоо үнэлгээг дундаж металл эквивалент тооцоолоход ашиглах ёстой.

Хэрэв металлургийн метал авалтын тухай мэдээлэл байхгүй, эсвэл боломжийн үнэмшилтэйгээр тооцоолох боломжгүй бол металл эквивалентад тулгуурлан тайлагнах нь тохиромжгүй байдаг.

Хайгуулын ажлын үр дүнгийн шатанд буй олон төслийн хувьд, метал авалтын тухай мэдээлэл байхгүй, эсвэл боломжийн үнэмшилтэйгээр тооцоолох боломжгүй байдаг. Ийм тохиолдолд металл эквивалентаар тайлагнах нь буруу юм.

Хавсралт В Заавар 1:**МТ Ангилал Хүснэгт 1:****ҮНЭЛГЭЭНИЙ БОЛОН ТАЙЛАГНАХ ШАЛГУУРЫН ХҮСНЭГТ**

ХҮСНЭГТ 1

ҮНЭЛГЭЭ БОЛОН ТАЙЛАГНАХ ШАЛГУУРЫН хүснэгт

Хүснэгт 1 бол Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийн тайлан боловсруулах үед лавлагаа болгон ашиглах ёстой заавар юм. Хамааралтай болон бодит байдал нь нийтэд ямар мэдээллийг тайлагнавал зохихыг тодорхойлсон шийдвэрлэх гол зарчим юм. Уншигчдын ойлголтод,

эсвэл тайлагнаж буй үр дүн буюу тооцооны боловсруулалтад бодитойгоор нөлөөлж болохуйц аливаа асуудлыг тайлагнах нь маш чухал. Энэ нь ялангуяа Хайгуулын ажлын үр дүн буюу Ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийн үнэлгээний мэдэгдлийн найдвартай байдал, эсвэл үнэмшилд хангалтгүй юм уу эргэлзээтэй өгөгдөл нөлөөлж буй үед маш чухал.

Мэргэшсэн этгээд нь Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, Ордын нөөцийг анх удаа тайлагнаж буй үед Хүснэгт 1-ийн агуулгын дагуу товч тайлбар өгөх хэрэгтэй. Материалын асуудал өөрчлөгдөж, Ил тод, бодит байдлын сонирхолд тайлбар өгөхийг шаардсанаас бусад үед уг хүснэгт нь дараагийн тайланг гүйцэтгэхийг шаарддаггүй. Мэргэшсэн этгээд нь тухайн хүснэгтийн тодорхой нэг зүйлд яагаад тайлбар өгөөгүй талаар, жишээлбэл тухайн зүйлд хамаарах мэдээлэл байхгүй, эсвэл тухайн зүйл нь яригдаж буй төсөлд хамаагүй тухай тайлбар өгөх шаардлагатай.

Нийтэд тайлагнах тайлангаас арилжааны нууц мэдээллийг хассан тохиолдолд, тус тайланд товч мэдээлэл (жишээ нь, эдийн засгийн таамаглалын тоон үнэ өртөг нь арилжааны нууц бол уг таамаглалыг тодорхойлоход ашигласан арга зүй) болон хөрөнгө оруулагчид буюу боломжит хөрөнгө оруулагчдад мэдээлэх зориулалттай агуулгыг оруулбал зохино.

Хүснэгт 1 дэх шалгуурын дараалал болон бүлэглэлт нь хайгуул, үнэлгээний ердийн системтэй аргачлалыг тусгадаг. Эхний “Дээжлэлтийн арга техник ба өгөгдөл” бүлэг дэх шалгуурыг дараагийн өүх бүлэгт хэрэглэнэ. Хүснэгтийн үлдсэн хэсэгт, өмнөх бүлгүүдэд жагсаасан шалгууруудыг дараагийн бүлэгт үе үе хэрэглэх бөгөөд үнэлгээ хийх, тайлагнах үедээ анхаарвал зохино.

Шалгуур	Тайлбар
	Дээжлэлтийн арга техник ба өгөгдөл (энэ бүлгийн шалгуурыг дараагийн бүх бүлэгт хэрэглэнэ)
Дээжлэлтийн арга техник	- Дээжлэлтийн мөн чанар ба чанар (жишээ нь, зүссэн суваг, санамсаргүй хэмхдэс г.м.) болон дээжийн төлөөлөх чадварыг нотлохоор авсан арга хэмжээ

Өрмийн техник	<ul style="list-style-type: none"> - Өрмийн хэлбэр(жишээ нь, керн/чөмөг,эсрэг эргэлт,задгай амтай алх,эргэлдэх агаарын цохилт,өрөм,цохилтотг.м)болон дэлгэрэнгүй тайлбар(жишээ нь, чөмөгний диаметр, гурвалсан буюу стандарт хоолой,алмаазан үзүүрийн гүн,дээж авах ир буюу бусад төрөл,чөмгийг зүүн зүг рүү эргүүлсэн эсэх, хэрэв тийм бол ямар аргаар г.м.)
Өрмийн дээжийн металл авалт	<ul style="list-style-type: none"> - Чөмгөн болон хэмхдэс дээжийн металл авалтыг зохих ёсоор тэмдэглэж, үр дүнг шинжилсэн эсэх. - Дээжийнметалл авалтыг ихэсгэх арга хэмжээ авч, дээжийн төлөөлөх чадварыг нотолсон эсэх. - Дээжийн металл авалт болон зэргийн хооронд харилцан уялдаа байгаа эсэх, нарийн/бүдүүн ширхэгтэй материалын хорогдол/нэмэгдлийн улмаас дээжийн зөрөө гарсан эсэх
Каротаж	<ul style="list-style-type: none"> - Харгалзах ашигт малтмалын баялгийн үнэлгээ, олборлолтын судалгаа болон металлургийн судалгааг нарийвчлан хийхээр чөмгөн болон хэмхдэс дээжийг тэмдэглэж бүртгэсэн эсэх. - Уг бүртгэл нь чанарын болон тоон шинж чанартай эсэх. Чөмгийн (эсвэлсуваг,каналг.м.)фотозураг.
Дээж хуваалтын техник ба дээж боловсруулалт	<ul style="list-style-type: none"> - Хэрэв чөмөг бол, зүсч буюу хөрөөдсөн эсэх, дөрөвний нэг, хагасыгнь буюу эсвэл бүхлээр нь авсан эсэх -Хэрэв чөмөг биш бол ховилдсон, хоолойгоор дээжилсэн, эргэлтэт хуваагч г.м эсэх, хуурай буюу чийгтэй дээжилсэн эсэх. - Бүх төрлийн дээжийн хувьд, дээж боловсруулах техникийн шинж чанар, чанар, тохиромжтой байдал. - Дээжийн төлөөлөх чадварыг ихэсгэхийн тулд дээж хуваалтын бүх шатанд мөрдөж буй чанарын хяналтын журмууд. - Газар дээр авсан материалыг төлөөлөх чадвартай дээжлэлт хийхэдзорилгоор авсан арга хэмжээ. - Дээжилсэн материалын ширхэглэгийн хэмжээнд дээжийн хэмжээ тохирох эсэх. - Дээжийн бүрэн бүтэн байдлыг хангахад авсан аюулгүйн арга хэмжээний талаарх мэдэгдэл байхыг зөвлөдөг.
Шинжилгээний өгөгдөл ба лабораторийн туршилтын чанарын хяналт	<ul style="list-style-type: none"> - Шинжилгээний болон лабораторийн ашиглаж буй аргачлалуудын шинж чанар, чанар, тохиромжтой байдал, арга техникийг бүтнээр нь эсвэл хэсэгчлэн авч үзэж байгаа эсэх. - Хэрэглэж буй чанарын хяналтын журмуудын мөн чанар (жишээ нь, стандартууд, хоосон дээж, дубликат дээж, лабораторийн гадаад шалгалт), нарийвчлал, давтацын зөвшөөрөгдөх хязгаарыг (өөрөөр хэлбэл хэвийсэн утгын хэмжээ) тогтоосон эсэх.
Дээжлэлт болон шинжилгээний шалгалт	<ul style="list-style-type: none"> - Биеэ дааж буюу өөр компаний ажилтнаар ноцтой зөрчил байгаа эсэхийг шалгах. - Хоёр нүхний хоорондох хазайлт буюу дубликат дээж хэрэглэх.
Өгөгдөл цуглуулсан цэгийн байршил	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын баялгийнүнэлгээ хийхэд ашиглах өрмийн нүхний байршилыг тогтооход ашиглаж буй судалгааны нарийвчлал ба чанар (цооногийн амсрын, доош цооногийн судалгаа),суваг,уурхайн ажилбар болон бусад байршил. - Топографийн хяналтын чанар ба зохистой байдал. Байршлын төлөвлөгөө.

Өгөгдлийн (дээжлэлтийн) зай ба тархалт	<ul style="list-style-type: none"> - Хайгуулын ажлын үр дүнг тайлагнахад зориулсан өгөгдлийн (дээжлэлтийн) зай. - Хэрэглэж буй Ашигт малтмал, Ордын нөөцийн тооцооны аргачлал болон ангилалд тохирох геологийн болон зэргийн үргэлжлэх талбайг тогтооход өгөгдлийн зай ба тархалт хангалттай эсэх. - Холимог дээж авсан эсэх.
Тайлагнах архив	<ul style="list-style-type: none"> - Тайлан боловсруулахад зориулсан анхдагч өгөгдлийн баримтжуулалт, өгөгдөл оруулах аргачлал, өгөгдлийн шалгалт, өгөгдлийн хадгалалт (биет болон цахим)
Геологийн бүтэцтэй холбоотой өгөгдлийн чиг баримжаа	<ul style="list-style-type: none"> - Дээжлэлтийн чиг баримжаагаар ордын төрлийг анхааран боломжийн бүтэцтэй, хэвийнсэн утга/зөрүү бүхий дээж авсан эсэх. - Өрөмдлөгийн баримжаа болон гол эрдэсжилтийн баримжааны хоорондох харилцан уялдааг дээжлэлтийн хэвийсэн утгад тооцсон бол үүнийг үнэлж, тайлагнавал зохино
Аудит, шүүмж	<ul style="list-style-type: none"> - Дээжлэлтийн арга техник, өгөгдөлд хйисэн аливаа аудит, шүүмжийн үр дүн
<p>Хайгуулын ажлын үр дүнг тайлагнах</p> <p>(өмнөх бүлэгт дурдсан шалгуурыг мөн энэ бүлэгт хэрэглэнэ)</p>	
Ашигт малтмалын баялгийн эрх зүй ба газрын эзэмшил	<ul style="list-style-type: none"> - Төрөл, лавлагаа нэр/дугаар, байршил болон хувьцаат компани, нөхөрлөл гэх зэрэг гуравдагч талтай байгуулсан хэлэлцээр, асуудлыг оролцуулсан эзэмшигч, ач холбогдолтой ашигт малтмал ашигласны төлбөр, орон нутгийн эрхийн ашиг сонирхол, түүхт газар, онгон зэрлэг байгаль буюу дархан цаазат газар, хүрээлэн буй орчны нөхцөл байдал. - Тухайн талбайд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авахад аливаа мэдэгдэж байгаа саад тотгорыг тайлагнах үед авсан эзэмшлийн аюулгүй байдал. - Ашигт малтмалын баялгийн эрх, нэрийг байрлуулах төлөвлөгөө. Техникийн тайланд эрдсийн нэрийг тайлбарлаж бичих нь албан ёсны санал гэж хүлээхгүй боловч зохиогчид ойлгомжтой байх товч бөгөөд тодорхой байвал зохистой.
Бусдын гүйцэтгэсэн хайгуулын ажил	<ul style="list-style-type: none"> - Бусдын гүйцэтгэсэн хайгуулын ажлын нотолгоо ба өртгийн үнэлгээ
Геологи	<ul style="list-style-type: none"> - Ордын төрөл, геологийн нөхцөл байдал ба эрдэсжилтийн төрөл. - Тайлбар хийхэд найдвартай геологийн зураг, хөндлөн огтлол байвал зохино.

Өгөгдөл нэгтгэх аргууд	<ul style="list-style-type: none"> - Хайгуулын ажлын үр дүн тайлагнахад, дундаж жиллэлтийн арга, хамгийн их ба бага зэргийн огтолсон цэг (жишээ нь, өндөр зэргийн зах), хязгаарын зэрэг нь үргэлж хамаатай бөгөөд тэмдэглэвэл зохино. - Өндөр зэрэгтэй үр дүнгийн богино хэмжээтэй болон бага зэрэгтэй үр дүнгийн урт хэмжээтэй хэрчмүүдийг нийлүүлэн нэгтгэж буй бол ингэж нэгтгэхэд хэрэглэсэн аргачлалыг тэмдэглэж, зарим нийтлэг жишээг нарийвчлан үзүүлбэл зохино. - Металл эквивалентын үнэ өртгийг тайлагнахад ашиглаж буй таамаглалыг тодорхой тэмдэглэвэл зохино.
Эрдсжилтийн өргөн ба хэрчмийн уртын хоорондох харилцан уялдаа	<ul style="list-style-type: none"> - Хайгуулын ажлын үр дүнг тайлагнахад эдгээр харилцан уялдаа маш чухал. - Эрдсийн тархалтын геометр нь өрмийн нүхний өнцгийн дагуу мэдэгдэж байвал үүний шинж чанарыг тайлагнах хэрэгтэй. - Хэрэв энэ нь мэдэгдэхгүй, зөвхөн өрмийн нүхний уртыг тайлагнасан бол энэ байдлын (жишээ нь, доош цооногийн урт, жинхэнэ өргөний мэдэгдэхгүй) талаар тодорхой тайлбар бичих хэрэгтэй
Диаграмм	<ul style="list-style-type: none"> - Хэрэв тийм диаграмм тайланг илт тодорхой болгож байвал, боломжтой бол, газрын зураг, хөндлөн огтлол(масштабтай нь) болон хэрчмийн хүснэгтийг аливаа материалыг нээн олж буй тухай тайланд оруулбал зохино.
Зохистой тайлан	<ul style="list-style-type: none"> - Хайгуулын ажлын бүх үр дүнг дэлгэрнгүй тайлагнах боломжгүй бол Хайгуулын ажлын үр дүнг буруу тайлагнахаас сэргийлэхийн тулд бага болон өндөр зэрэг, өргөнийг хоёуланг нь төлөөлөхүйц тайлан байх нь зохистой.
Бусад үндэслэлтэй Хайгуулын ажлын өгөгдөл	<ul style="list-style-type: none"> - Хэрэв ач холбогдолтой, бодитой бол, дараах (гэхдээ үүгээр хязгаарлахгүй) хайгуулын ажлын бусад өгөгдлийг тайлагнах хэрэгтэй. Үүнд: геологийн ажиглалт; геофизикийн судалгааны үр дүн; геохимийн судалгааны үр дүн; бөөн дээжийн – хэмжээ, боловсруулах арга; металлургийн туршилтын үр дүн; бөөн дээжийн нягт; гүний ус; геотехникийн болон чулуулгийн шинж чанар; болзошгүй хорт буюу бохирдуулагч хольц.
Цаашидын ажил	<ul style="list-style-type: none"> - Цаашид хийхээр төлөвлөсөн ажлын мөн чанар, цар хүрээ (жишээлбэл, хажуу тийш буюу гүн рүү өргөтгөх, том хэмжээтэй буюу том алхамтай өрөмдлөг).
<p>Ашигт малтмалын үнэлгээ, тайлагналт (эхний бүлгийн, холбоотой бол хоёр дахь бүлгийн шалгуурыг мөн энэ бүлэгт хэрэглэнэ)</p>	
Өгөгдлийн сангийн бүрэн байдал	<ul style="list-style-type: none"> - Анхдагч цуглуулсан өгөгдөл болон үүнийг Ашигт малтмалын баялгийн үнэлгээний зориулалтаар хэрэглэх хооронд жишээлбэл хуулан бичихэд буюу түлхүүрдэх алдаагаар өгөгдлийг гуйвуулахаас сэргийлж авах арга хэмжээ. - Ашиглаж буй өгөгдлийг шалгах, баталгаажуулах аргачлал
Геологийн боловсруулалт	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын ордын геологийн боловсруулалт дахь үнэмшил (эсрэгээр авч үзвэл эргэлзээ.) - Ашигласан өгөгдөл, хийсэн аливаа таамаглалын мөн чанар. - Хэрэв байвал, Ашигт малтмалын баялгийн үнэлгээнд хэрэглэсэн өөр боловсруулалтын сөрөг нөлөө. - Ашигт малтмалын баялгийн үнэлгээний заавар, хяналтанд хэрэглэгдэх геологийн мэдээлэл. - Зэрэг болон геологийн үргэлжлэх талбайд нөлөөлөх хүчин зүйлс.

Хэмжээсүүд	<ul style="list-style-type: none"> - <i>Ашигт малтмалын баялгийн урт (суналын дагуу буюу бусдаар), өргөн болон гадаргуугаас ддэ, доод хязгаар хүртэлх гүн илэрхийлсэн цар хүрээ, хувьсах чанар</i>
Үнэлгээ, загварчлалын арга техник	<ul style="list-style-type: none"> - <i>Ашиглаж буй үнэлгээний аргын мөн чанар, тохиромжтой байдал болон хамгийн дээд зэргийн утга, домэйн, интерполяцийн параметр, өгөгдлийн цэгээс экстраполяц хүртэлх хамгийн их зайг оролцуулсан гол таамаглалууд.</i> - <i>Тооцоо, өмнөх тооцоо, болон олборлолтын бүтээгдэхүүний бүртгэлийн хяналт шалгалттай байх, Ашигт малтмалын баялгийн үнэлгээ тооцоонд тийм өгөгдлийг тооцон үзсэн эсэх.</i> - <i>Завсрын бүтээгдэхүүний металл авалттай холбогдуулан хийсэн таамаглал.</i> - <i>Хортой элемент болон бусад эдийн засгийн ач холбогдолгүй хувьсагч (жишээ нь хүчлээр урсгах олборлолтонд хүхэр)-ийн үнэлгээ.</i> - <i>Блок загварчлалын интерполяцын тохиолдолд, дээжийн дундаж зай болон хайлттай холбоотой блокын зайг хэрэглэнэ</i> - <i>Ангилан олборлох нэгжийг загварчлах аливаа таамаглал (жишээ нь, шугаман бус регресс).</i> - <i>Хувьсагчуудын хоорондох хамаарлын тухай аливаа таамаглал</i> - <i>Баталгаажуулалтын процесс, ашиглаж буй процессыг шалгах, загварчлалын өгөгдлийг өрмийн цооногийн өгөгдөлтэй харьцуулах, боломжтой бол өгөгдлийг зохицуулах.</i> - <i>Багтаамж болон зэргийг тооцоолоход ашиглаж арга, хийсэн таамаглалын дэлгэрэнгүй тайлбар(зүсэлт, полигон, урвуу зай, геостатистикийн болон бусад арга).</i> - <i>Нөөцийн үнэлгээг хянахад геологийн боловсруулалтыг хэрхэн ашигласан тухай тодорхойлолт.</i> - <i>Зэргийн огтлол буюу хучилтыг ашиглах, эс ашиглах үндэслэлийн тухай хэлэлцүүлэг. Хэрэв компьютерийн арга сонгосон бол хэрэглэсэн программ хангамж, параметрийн тодорхойлолт.</i> - <i>Геостатистикийн аргууд нь маш олон янз бөгөөд дэлгэрэнгүй тайлбарлах хэрэгтэй. Сонгосон аргыг сайтар нотлох хэрэгтэй. Themethodchosenshouldbejustified. Вариограмм гэх зэрэг геостатистикийн параметрууд, тэдгээрийн геологийн боловсруулалттай нмйцэх байдлын талаар хэлэлцвэл зохино. Төсөөтэй ордуудад геостатистик хэрэглэхэд олж авсан дадлага туршлагыг анхаарвал зохино.</i>
Чийг	<ul style="list-style-type: none"> - <i>Багтаамжийн утгыг хуурай масс дээр, эсвэл байгалийн чийгтэйд нь тооцсон эсэх, чийгийн агуулгыг тодорхойлсон арга.</i>
Хязгаарын/захын параметрууд	<ul style="list-style-type: none"> - <i>Хязгаарын зэрэг буюу чаанрын параметрийг гаргаж авах үндэслэл, тохирох бол эквивалент металлын томьёоны үндэс.</i>

<p>Олборлолтын хүчин зүйлс буюу таамаглал</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Боломжит олборлолтын аргуудад хамааруулан хийсэн таамаглал, хамгийн олборлох хэмжээ, дотоод (эсвэл, боломжтой бол, гадаад) олборлолтын хорогдол. Ашигт малтмалыг үнэлэх үед олборлолтын арга болон параметртай холбоотой таамаглалыг байнга хийх боломжгүй байж болно. Таамаглал хийгээгүй бол энэ талаар тайлагнах хэрэгтэй.</i> - <i>Эдийн засгийн эцсийн олборлолт хийх бодит төлвийг харуулахын тулд, суурь таамаглал хийх шаардлагатай. Үүний жишээнд хандалтын арга (босоо ам, налалт г.м.), геотехникийн параметрууд (уурхайн налуу, таазны хэмжээг м.) дэд бүтцийн шаардлагууд, тооцоолсон уурхайн зардал. Бүх таамаглалыг тодорхой бичих хэрэгтэй.</i>
<p>Металлургийн хүчин зүйлс буюу таамаглал</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Санал болгох металлургийн процесс болон түүний эрдэсжилтийн төрөлд тохирох байдал. Ашигт малтмалыг тайлагнах үед металлургийн боловсруулалтын процесс, параметртай холбогдуулан үргэлж таамаглал хийх нь боломжгүй байж болно. Таамаглал хийгээгүй бол тайлагнах хэрэгтэй.</i> - <i>Эдийн засгийн эцсийн олборлолт хийх бодит төлвийг харуулахын тулд, суурь таамаглал хийх шаардлагатай. Үүний жишээнд металлургийн туршилтын ажлын хэмжээ, металл авалт, завсрын бүтээгдэхүүний буюу хортой элементийн хувь хэмжээ, дэд бүтцийн шаардлагууд, тооцоолсон уурхайн зардал. Бүх таамаглалыг тодорхой бичих хэрэгтэй.</i>
<p>Бөөн дээжийн нягт</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Таамагласан буюу тодорхойлсон эсэх. Таамагласан бол, таамаглалын үндэс. Тодорхойлсон бол, ашигласан арга, чийгтэй буюу хуурай, хэмжлийн давтамж, дээжийн мөн чанар, хэмжээ, төлөөлөх чадвар.</i>
<p>Ангилал</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Ашигт малтмалыг үнэмшлийн хувьсах категоороор ангилах үндэслэл.</i> - <i>Холбогдох бүх хүчин зүйлсийг авч үзсэн эсэх, өөрөөр хэлбэл багтаамж/зэргээр тооцоолоход гарах харьцангуй үнэмшил, геологи болон металлын утгын үргэлжлэх талбайн үнэмшил, өгөгдлийн чанар, тоо хэмжээ, тархалт.</i> - <i>Тухайн ордын талаарх Чадавхтай ажилтны үзэл бодлыг үр дүнд тусгасан эсэх.</i>
<p>Аудит, шүүмж</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Ашигт малтмалын баялгийн үнэлгээнд хийсэн аливаа аудит, шүүмжийн үр дүн</i>
<p>Харьцангуй нарийвчлал/ үнэмшлийн тухай хэлэлцүүлэг</p>	<ul style="list-style-type: none"> - <i>Шаардлагатай бол Чадавхтай ажилтны тохиромжтой гэж үзсэн арга аргачлал ашиглан хийсэн Ашигт малтмалын баялгийн үнэлгээн дэх харьцангуй нарийвчлал болон/буюу үнэмшлийг тэмдэглэх. Жишээлбэл, Ашигт малтмалын баялгийн харьцангуй нарийвчлалыг өгөгдсөн үнэмшилд магадлалын мужид тооцоолоход статистик буюу геостатистик аргачлал хэрэглэх, эсвэл тухайн аргачлал тохирохгүй гэж үзвэл үнэлгээний харьцангуй нарийвчлал болон үнэмшилд нөлөөлөх хүчин зүйлсийн чанарын үнэлгээ.</i> - <i>Тухайн тайлбар нь нийт буюу хэсэгчилсэн үнэлгээнд хамаарах эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Хэрэв хэсэгчилсэн бол техник эдийн засгийн үндэслэлд хамаарахгүй байх багтаамж буюу эзэлхүүнээр өгөх хэрэгтэй. Хийсэн таамаглал, ашигласан аргачлалыг баримт бичигт тусгах хэрэгтэй.</i> - <i>Шаардлагатай бол, үнэлгээний харьцангуй нарийвчлал, үнэмшлийн тайлбарыг үйлдвэрлэлийн мэдээлэлтэй харьцуулах хэрэгтэй.</i>

Ашигт малтмалын баялгийн үнэлгээ, тайлагналт	
<i>(эхний бүлгийн, холбоотой бол өмнөх бусад бүлгийн шалгуурыг мөн энэ бүлэгт хэрэглэнэ)</i>	
<i>Ордын нөөц рүү хувиргах Ашигт малтмалын баялгийн үнэлгээ</i>	<ul style="list-style-type: none"> - Ордын нөөц рүү хувиргахад үндэслэл блогон хэрэглэсэн Ашигт малтмалын баялгийн үнэлгээний тодорхойлолт. - Ашигт малтмалыг Ордын нөөцөд нэмж буюу оруулж тайлагнах эсэх тухай тодорхой мэдээгдэл.
<i>Судалгааны байдал</i>	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалыг Ордын нөөц рүү хувиргахаар хийсэн судалгааны төрөл, түвшин. - Ашигт малтмалыг Ордын нөөц рүү хувиргахын тулд эцсийн техник эдийн засгийн үндэслэлийн судалгааг хийсэн байхыг МТ Ангилал шаарддаггүй боловч Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийн түвшин дэх судалгаагаар ядаж техникийн хувьд хийгдэх боломжтой, эдийн засгийн хувьд амьдрах чадвартай олборлолтын төлөвлөгөөг тодорхойлсон байх, бүх Нөлөөлөгч хүчин зүйлсийг тооцсон байхыг шаарддаг.
<i>Хязгаарын/захын параметрууд</i>	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай бол эквивалент металлын томъёоны суурийг багтаасан, ашиглаж буй хязгаарын зэрэг, чанарын параметруудын суурь.Хязгаарын параметр нь зэргээс илүү блок дахь эдийн засгийн үнэ өртөг байна.
<i>Олборлолтын хүчин зүйлс буюу таамаглал</i>	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалыг Ордын нөөц рүү хувиргахад ашигласан арга, таамаглал (өөрөөр хэлбэл, тохирох хүчиний зүйлс ашиглан оновчилсон буюу эсвэл анхдагч буюу нарийвчилсан загвараар). - Сонгосон олборлолтын аргын сонголт, мөн чанар, тохиромжтой байдал, сонгосон олборлолтын нэгж(урт, өргөн, өндөр)-ийн хэмжээ, урьдчилсан зурвас, хандалт г.м дизайнтай холбоотой асуудлуудыг багтаасан олборлолтын бусад параметр. - Геотехникийн параметртай холбоотой хийгдэн таамаглал (жишээ нь, уурхайн налуу, мөргөцөгийн налууугийн хэмжээ г.м.), зэргийн хяналт болон урьдчилсан үйлдвэрлэлийн өрөмдлөг. - Уурхайн оновчлолд ашигласан гол таамаглалууд ба Ашигт малтмалын баялгийн загварчлал (шаардлагатай бол). - Олборлолтын хорогдлын хүчин зүйлс, олборлолтын металл авалт, олборлолтын хамгийн бага өргөн. - Сонгосон олборлолтын аргад тавигдах дэд бүтцийн шаардлагууд. Боломжтой бол, гүйцэтгэлийн параметруудын уламжлалт найдвартай байдал.

<p>Металлургийн хүчин зүйлс буюу таамаглал</p>	<ul style="list-style-type: none"> - Санал болгох металлургийн процесс, уг процессийн эрдэсжилтийн төрөлд тохиромжтой байдал. - Тухайн металлургийн процесс нь сайтар судлагдсан технологи буюу байгальд шинээр бий болсон эсэх. - Хийгдсэн металлургийн туршилтын ажлын мөн чанар, хэмжээ болон ашигласан металлургийн металл авалтын хүчин зүйлс. - Хорт элементийн талаар хийсэн аливаа таамаглал буюу нотолгоо. - Ямарваа бөөн дээж буюу хагас үйлдвэрлэлийн туршилт байгаа эсэх, тийм дээжийн хүдрийн биетийг бүхэлд нь төлөөлөх чадварын түвшин. - Ордын нөөцийг тайлагнасан багтаамж болон зэрэг нь үйлдвэр рүү орж байгаа материалтай холбоотой буюу эсвэл металл авалтын дараа эсэхийг тодорхой тэмдэглэвэл зохино. бэлэн байгаа үйлдвэр, тоног төхөөрөмж, нөхвөр болон үлдэгдэл үнийн талаар тайлбар бичнэ.
<p>Орлого, зардлын хүчин зүйлс</p>	<ul style="list-style-type: none"> - Төслийн хөрөнгө, ажлын өртөгтэй холбоотой хазайлт буюу хийсэн таамаглал. - Дээд зэрэг, металл буюу барааны үнийн ханш, тээвэрлэлт болон боловсруулалтын зардал, торгууль гэх зэргийг багтаасан орлогод хамааруулан хийсэн таамаглал. - Төрд болон хувьд төлөх нөөц ашигласны төлбөрийн талаар хийсэн нотолгоо. <p>-Тогтоосон хугацаандахь үндсэн мөнгөн гүйлгээний урсгал</p>
<p>Зах зээлийн үнэлгээ</p>	<ul style="list-style-type: none"> - Тухайн түүхий эдийн хэрэгцээ, хангамж, барааны нөхцөл байдал, хэрэглээний чиг хандлага, хүчин зүйлс нь цаашдын хангамж, хэрэгцээнд нөлөөлж магадгүй юм. - Бүтээгдэхүүнд зах зээлийн цонхонд таарсан тодорхойлогч ашиглан хийх хэрэглэгч, өрсөлдөгчийн шинжилгээ. - Үнэ болон хэмжээний талаарх урьдчилсан таамаглал, энэхүү таамаглалын суурь үндэс. - Үйлдвэрлэлийн эрдсийн хувьд хэрэглэгчийн тодорхойлолт, хангамжийн гэрээ байгуулахаас өмнө тавигдах сорилт туршилтын болон хүлээн зөвшөөрөх шаардлага.
<p>Бусад</p>	<ul style="list-style-type: none"> - Хэрэв байгаа бол, Ашигт малтмалын баялгийн үнэлгээ, ангилал тогтоох төслийн амьдрах чадварт байгалийн эрсдэл, дэд бүтэц, байгаль орчин, эрх зүй, зах зээл, нийгмийн буюу төрийн хүчин зүйлсээс үзүүлэх нөлөө. - Уул уурхайн түрээс, төлбөрийн зөвшөөрөл, төрийн болон хууль ёсны зөвшөөрөл зэрэг төслийн амьдрах чадварт чухал нөлөөтэй нэр цол, зөвшөөрлүүдийн статус. - Хүлээгдэж буй өр төлбөрийн хүрээлэн буй орчны тодорхойлолт. Ашигт малтмалын баялгийн эрх, нэр цолыг байршуулах төлөвлөгөө.
<p>Ангилал</p>	<ul style="list-style-type: none"> - Ордын нөөцийг өөр өөр үнэмшилтэй категор руу ангилах үндэслэл - Үр дүн Чадавхтай ажилтны ордын талаарх үзэл санаатай таарч байгаа эсэх. - Бодитой Ашигт малтмалаас (хэрэв байгаа бол) гараж авсан Магадалсан Ордын нөөцийн хувь.
<p>Аудит, шүүмж</p>	<ul style="list-style-type: none"> - Ордын нөөцийн үнэлгээнд хийсэн аливаа аудит, шүүмжийн үр дүн

<p>Харьцангуй нарийвчлал/үнэмшлийн тухай хэлэлцүүлэг</p>	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай бол Чадавхтай ажилтны тохиромжтой гэж үзсэн арга аргачлал ашиглан хийсэн Ордын нөөцийн үнэлгээн дэх харьцангуй нарийвчлал болон/буюу үнэмшлийг тэмдэглэх. Жишээлбэл, нөөцийн харьцангуй нарийвчлалыг өгөгдсөн үнэмшилд магадлалын мужид тооцоолоход статистик буюу геостатистик аргачлал хэрэглэх, эсвэл тухайн аргачлал тохирохгүй гэж үзвэл үнэлгээний харьцангуй нарийвчлал болон үнэмшилд нөлөөлөх хүчин зүйлсийн чанарын үнэлгээ. - Тухайн тайлбар нь нийт буюу хэсэгчилсэн үнэлгээнд хамаарах эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Хэрэв хэсэгчилсэн бол техник эдийн засгийн үндэслэлд хамаарахгүй байх багтаамж буюу эзэлхүүнээр өгөх хэрэгтэй. Хийсэн таамаглал, ашигласан аргачлалыг баримт бичигт тусгах хэрэгтэй. - Шаардлагатай бол, үнэлгээний харьцангуй нарийвчлал, үнэмшлийн тайлбарыг үйлдвэрлэлийн мэдээлэлтэй харьцуулах хэрэгтэй.
<p>Алмааз, бусад үнэт чулуунэлгээ, тайлагналт</p> <p>(бусад холбогдох бүлэг дэх шалгуурыг энэ бүлэгт бас хэрэглэнэ)</p>	
<p>Индикатор эрдсүүд</p>	<ul style="list-style-type: none"> - Хими/физикийн онцлог шинж чанараараа ялгаатай анар, ильменит, хромт шпинель, хромт диопсид гэх мэт индикатор эрдсүүдийн тайланг тохирох мэргэжисэн лабораториор гүйцэтгүүлбэл зохино.
<p>Алмаазын эх үүсвэр</p>	<ul style="list-style-type: none"> - Алмаазын хэлбэр, хэмжээ, өнгөний дэлгэрэнгүй тайлбар, алмаазын эх үүсвэр (анхдагч буюу хоёрдогч)-ийн мөн чанар, чулуулгийн төрөл, геологийн орчин.
<p>Дээж авалт</p>	<ul style="list-style-type: none"> - Дээжийн төрөл, илэрц/ил гарсан чулуу, бул чулуу, өрмийн чөмөг, урвуу эргэлтийн өрмийн зүсэлт, хайрга, урсгалын тунамал буюу хөрс эсэх, болон зориулалт, өөрөөр хэлбэл эзэлхүүний буюу бөөн дээжний нэг нэгж дэх чулууг тогтоохын тулд том диаметртай өрөмдлөг хийх. - Дээжийн хэмжээ, тархалт, төлөөлөх байдал.
<p>Дээжийн боловсруулалт</p>	<ul style="list-style-type: none"> - Тоног төхөөрөмжийн төрөл, боловсруулалтын хэмжээ, итгэмжлэл. - Дээжийн хэмжээг багасгах арга. Доод шигшүүрийн хэмжээ, дээд шигшүүрийн хэмжээ, дахин бутлалт. - Боловсруулалт(нягт орчин/хүнд шингэний орчин дахь ялгалт, тос, рентген туяа, гараар сортолж ялгах г.м.). - Боловсруулалтын бүтээмж, хаягдлын хяналт, гранулометр. - Ашиглаж буй лаборатори, микро-алмаазад хэрэглэж буй боловсруулалт болон итгэмжлэл.
<p>Карат</p>	<ul style="list-style-type: none"> - Тавны нэг (0.2) грамм(ихэнх тохиолдолд метрийн карат буюу MC гэж тодорхойлдог).

<p>Дээжийн зэрэг</p>	<ul style="list-style-type: none"> - Хүснэгт 1-ийн энэ бүлэг дэх Дээжийн зэрэг гэдэг нь масс, талбай буюу эзэлхүүний нэгж дэх карат байдлаар хэрэглэгдэнэ. - Тодорхой заасан доод хязгаарын шигшүүр дээрх дээжийн зэргийг хуурай метрийн тонн дахь карат буюу 100 хуурай метрийн тонн дахь каратаар тайлагнавал зохино. Тунамал ордын хувьд, тооцоондоо жинд суурилсан эзэлхүүнийг хамт өгсөн бол дээжийн зэргийг квадрат метр дэх карат буюу куб метр дэх каратаар өгөхийг зөвшөөрөх боломжтой. - Эзэлхүүн, нягтыг үнэлэх ерөнхий шаардлагаас гадна, чулууны давтамж (куб метр дэх буюу тонн дахь чулуу)-г чулууны хэмжээ (чулуун дахь карат)-тэй харьцуулж дээжийн зэрэг (тонн дахь карат)-ийг гаргах хэрэгтэй байдаг.
<p>Хайгуулын ажлын үр дүнг тайлагнах</p>	<ul style="list-style-type: none"> - Фазууд дахь шигшүүрийн хэмжээний стандарт прогрессийг ашиглан гарагсан шигшүүрийн иж бүрдэл өгөгдөл. Бөөн дээжлэлтийн үр дүн, фаз дахь нийт дээжийн зэрэг. Торон бүтцийн шинжилгээ, зэргийн тархалт. Чулууны хэмжээ ба тоон тархалт. Дээжийн анхдагч оролт ба хаягдлын ширхэглэгийн гранулометр - Дээжийн нягтын тодорхойлолт. - Хувиар илэрхийлсэн агууламж/концентрац ба дээжийн шүүлтүүрээр гарсан хэмжээ. - Доод хязгаарын шигшүүрийн хэмжээсийг өөрчлөхөд гарах дээжийн зэрэг. - Дээжийн үйлдвэрийн гүйцэтгэл болон арилжааны хэмжээний гүйцэтгэлийн хувьд хийсэн ширхэглэгийн тархалтын тохируулга. - Хэрэв тохирох буюу хэрэглэх бол, хайгуулын ажлын алмаазын дээжийн ширхэглэгийн тархалтаас чулууны хэмжээ, тархалт буюу давтамжийг зашварчлахад геостатистикийн арга хэрэглэдэг. - Алмааз нь арилжааны ач холбогдлын хувьд хэт жижиг гэж үзвэл тайланд алмаазын жинг зөвхөн бичихгүй байж болно. Энэхүү доод хязгаарын хэмжээг тэмдэглэх хэрэгтэй
<p>Ашигт малтмал, Ордын нөөцийг тайлагнахад зориулан зэргийг үнэлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Дээжийн төрөл болон зэргийн үнэлгээ хийх зориулалттай өрөмдлөг буюу дээжлэлтийн торон/тоонолжин зохион байгуулалтын талаарх тодорхойлолт. - Дээжийг бутлах хэмжээ, үүний ба арилжааны боловсруулалтын үйлдвэрт хэрэглэж болох хэмжээ хоорондох харилцан уялдаа. - Тогтоож тайлагнасан доод хязгаарын шигшүүрийн хэмжээнээс том ширхэгтэй алмаазын нийт тоо. - Тогтоож тайлагнасан доод хязгаарын шигшүүрийн хэмжээнээс том ширхэгтэй алмаазын нийт жин. - Тогтоож доод хязгаарын шигшүүрийн хэмжээнээс том ширхэгтэй дээжийн зэрэг.

<p>Үнэ өртгийн ойролцоо үнэлгээ</p>	<ul style="list-style-type: none"> - Хайгуулын ажлын дээжийг баяжуулахад нийтлэг хэрэглэдэг нийт ангижруулалтын аргаар баяжуулсан алмаазын дээжинд үнэ өртгийн үнэлгээ хийхгүй. - Тийм мэдээллийг хэр хэмжээнийх нь хувьд арилжааны нууц гэж үзэхгүй. Нийтэд тайлагнах тайланд дараах мэдээллийг оруулбал зохино. Үүнд: <ul style="list-style-type: none"> <input type="checkbox"/> Фаз буюу гүн дэх шигшүүрийн тохирох хэмжээгээр өгөгдсөн алмаазын тоо хэмжээ. <input type="checkbox"/> Үнэ өртгийг тогтоож буй боодлын дэлгэрэнгүй тайлбар. <input type="checkbox"/> Чулууны тоо, карат, фаз буюу гүн дэх доод хязгаарын хэмжээ. <input type="checkbox"/> <input type="checkbox"/> Сонгосон ёроолын хязгаар дахь дундаж\$/карат болон\$/тонн үнэ өртгийг Америк доллараар өгвөл зохино. Каратын үнэ нь төслийн үнэ өртгийг үзүүлэхэд чухал ач холбогдолтой. <input type="checkbox"/> Үнэ тогтоосон үндэслэл(жишээ нь, дилерийн худалдаж авах үнэ, дилерийн худалдах үнэ г.м.). <input type="checkbox"/> Алмаазын сэв гэмтлийн үнэлгээ. <input type="checkbox"/> Үнэ өртгийг үнэлэхэд төлөөлөхүйц хамгийн бага боодлын хэмжээ.
<p>Аюулгүй ба бүрэн бүтэн байдал</p>	<ul style="list-style-type: none"> - Итгэмжлэгдсэн баяжуулалтын аудит. - Дээжийг малтаж авсны дараа лацадсан эсэх. - Үнэлэгчийн байршил, дагалдан хамгаалалт, хүргэлт, цэвэрлэгээний хорогдол, бүртгэсэн дээжийн карат ба чулууны тоог тааруулах. - Микро-алмаазын боловсруулалтын өмнө чөмгөн дээжийг угаана. - Өөр газарт боловсруулсан дээжинд аудит хийх. - Хаягдлыг шалгасан дүн. - Дээжлэлт, боловсруулалтанд хэрэглэсэн тэмдэгт мониторын авалт. - Геофизик(ус нэвчүүлсэн) нягт ба мөхлөгийн нягт. - Дээжийн нойтон ба хуурай жин, нүхний эзэлхүүн ба нягт, чийгийн коэффициентийн хөндлөн баталгаажуулалт.
<p>Ангилал</p>	<ul style="list-style-type: none"> - Эзэлхүүн, нягтыг үнэлэх ерөнхий шаардлагаас гадна, чулууны давтамж (куб метр дэх буюу тонн дахь чулуу)-г чулууны хэмжээ (чулуун дахь карат)-тэй харьцуулж дээжийн зэрэг (тонн дахь карат)-ийг гаргах хэрэгтэй байдаг. Энэхүү үнэлгээн дэх эргэлзээний элементүүдийг анхааран үзэж, үүндээ тулгуурлан ангилал хийвэл зохино.

Хавсралт СЗаавар 2:

МТ Ангилал ХАВСРАЛТ 1

ЕРӨНХИЙ НЭР ТОМЪЁО БА ИЖИЛ ЗҮЙЛС

ХАВСРАЛТ1 ЕРӨНХИЙ НЭР ТОМЬЁО БА ИЖИЛ ЗҮЙЛС

МТ Ангилалд, зарим үг ерөнхий утгаар хэрэглэгддэг боловч үйлдвэрлэлийн хүрээнд зарим онцгой түүхий эдийн бүлэгт илүү тусгай утгыг тэдгээр үгэнд хавсаргаж болно. Шаардлагагүйгээр давхцуулахаас зайлсхийхийн тулд, ерөнхий нэр томьёонуудыг энэхүү баримт бичгийн зорилгод нийцэн ижил утгатай байж болох бусад нэр томьёотой хамт доор жагсаан бичлээ.

Ерөнхий нэр томьёо	Ижил утгатай буюу ойролцоо нэр томьёо	Зориулсан ерөнхийлсөн утга
Олборлолт	Олзворлолт/ухалт	Металл, нүүрс, ашигт малтмал, үнэт чулууг гадаргаас буюу газар доороос ямарваа арга (олзворлох, ил уурхай, ил арга, уусган олборлолт, газар ухах)-аар газраас салгаж олборлохтой холбоотой бүх үйл ажиллагаа
Багтаамж	Тоо хэмжээ, эзэлхүүн	Хэмжлийн нэгжээс хамааралгүйгээр (тоогоор тайлагнасан үед ямар нэгж болохыг заах хэрэгтэй) сонирхож буй материалын тоо хэмжээг илэрхийлсэн хэмжээ
Зэрэг	Чанар, Сорилт, Шинж илгээ (Үнэ өртөг)	Сонирхож буй материалын шинж чанарыг дээж буюу бүтээгдэхүүнд тодорхойлох аливаа физик буюу химийн хэмжил. Алмааз болон үнэт чулуунд чанар гэдэг нэр томьёо өөр тусгай утгатай болохыг анхаарна уу.
Металлург	Боловсруулалт, Баяжуулалт, Баяжмал боловсруулалт	Ихээхэн жинтэй дээжээс сонирхож буй бүрэлдэхүүн хэсгийг физик болон/буюу химийн аргаар ялган салгалт. Олборлосон материалаас эцсийн таваарын бүтээгдэхүүн гаргахад хэрэглэдэг аргууд. Үүний жишээнд шигшилт, флотац, соронзон сепарац, уусгалт, угаалт, шатаалт г.м орно.
Металл авалт	Гарц	Олборлолт болон/буюу боловсруулалтын үед гарган авсан сонирхож буй анхдагч материалын зууны хувь. Олборлолт буюу боловсруулалтын бүтээмжийн хэмжээс.
Эрдэсжилт	Ордын төрөл, хүдрийн бие, эрдэсжилтийн хэлбэр.	Эдийн засгийн сонирхол татаж буй массад, буюу ордод илэрч буй аливаа дан эрдэс буюу эрдсийн нийлмэл. Энэхүү нэр томьёо нь эрдэсжилт үүсч болох бүх хэлбэр маягийг ордын анги, илэрцийн горим, гарал үүсэл буюу найрлагаар нь хамрах зориулалттай.

Ордын нөөц	Хүдрийн нөөц	МТ Ангилалт “Ашигт малтмал”-ыг эрхэмлэдэг боловч “хүдэр” нь түгээмэл хэрэглэгддэг, ерөнхийдөө хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Бусад тодорхойлогч, жишээ нь нүүрсний нөөц, алмаазын нөөц гэх мэтийг энэхүү утгыг тодорхойлоход хэрэглэж болно.
Хязгаарын/захын зэрэг	Бүтээгдэхүүний техник үзүүлэлт	Эдийн засгийн хувьд олборлох боломжтой болохыг тодорхойлох, өгөгдсөн ордод байгаа эрдэсжсэн материалын хамгийн бага зэрэг буюу чанар. Эдийн засгийн үнэлгээний үндсэн дээр, эсвэл бүтээгдэхүүний зөвшөөрөгдөх үзүүлэлтийг тогтоож буй физик буюу химийн онцлог шинж чанар дээр тулгуурлаг тогтоож болно.
Алмааз	Үнэт чулуу	Ижил шинж чанартай алмааз болон бусад үнэт чулуу.
Чадавхтай ажилтан	Мэргэшсэн хүн(Канад),Мэргэшсэн чадавхтай хүн(Чили)	Чадавхтай ажилтны тодорхойлолтыг МТ Ангиллын 11 дүгээр зүйлээс харна уу.
Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл	Анхдагч техник эдийн засгийн үндэслэл	Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл нь олборлох аргын, тухайлбал газрын гүний уурхай, буюу нүхэн хэлбэрийн тохиолдолд, эсвэл ил уурхайн тохиолдолд аль тохиромжтойг нь сонгох шатанд хүрсэн, ашигт малтмалын боловсруулалтын үр ашигтай аргыг нь тогтоосон ашигт малтмалын төслийн техник эдийн засгийн амьдрах чадварыг өргөн сонголтын хүрээнд нарийвчлан судалж буй судалгаа юм. Үүнд, Нөлөөлөгч хүчин зүйлсийн боломжит таамаглалд тулгуурласан санхүүгийн шинжилгээ болон Чадавхтай ажилтны зүгээс тайлагнах мөчид Ашигт малтмалын баялгийг бүхэлд нь буюу зарим хэсгийг Ордын нөөцөд хувиргаж болох эсэхийг тогтооход хангалттай, холбогдох бусад хүчин зүйлс багтдаг. Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийн үнэмшилт магадлал нь техник эдийн засгийн үндэслэлийнхээс бага байна.

Техник эдийн засгийн үндэслэл		Техник эдийн засгийн үндэслэл нь тухайн ашигт малтмалын төслийн хувьд сонгосон боловсруулалтын аргын техник эдийн засгийн нарийвчилсан судалгаа бөгөөд ашиглах боломжтой Нөлөөлөгч хүчин зүйлс болон бусад холбогдох ажлын хүчин зүйлсийн дэлгэрэнгүй үнэлгээ, мөн тайлагнах мөчид олборлолт явуулах нь боломжтой (эдийн засгийн хувьд олборлох боломжтой)-г нотлоход шаардлагатай санхүүгийн нарийвчилсан шинжилгээг багтаана. Энэхүү судалгааны үр дүн нь төслийн ажлыг үргэлжүүлэх буюу санхүүжүүлэхийн тулд хэрэгжүүлэгч буюу санхүүгийн байгууллагаас эцсийн шийдвэр гаргах үндэслэл болох боломжтой. Энэ судалгааны үнэмшилт магадлал нь Урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийнхээс өндөр байдаг.
-------------------------------	--	--

Хавсралт D Сургалт:

**Хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмал,
Ордын нөөцийг нийтэд тайлагнах, Харри
Паркер, Монголын Геологи уул уурхайн
мэргэжлийн институт,
2014 оны 5 сарын 2**

Хавсралт EСургалт:

Жагсаан бичих дүрэм болон Тайлагнах ангилал, Монгол улсын Санхүүгийн ажилтнуудад зориулсан илтгэл, Зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагууд (“RPOs”) болон Үндэсний тайлагнагч байгууллагууд (“NROs”), Чадавхтай ажилтанболонМэргэшсэн итгэмжлэгдсэн мэргэжилтний зүгээс тогтоох Техник эдийн засгийн үндэслэл ба Хүдрийн нөөц

Жереми Петерс,Гэрлээ Баянжаргал, 2014 оны 6 сарын 18-20

Хавсралт F Сургалт :

**Нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх семинар,
CRIRSCO Жил бүрийн хурал 2014,
CRIRSCOҮндэсний тайлагнагч
байгууллагуудынГишүүд, 2014 оны 10 сарын 18**

(Семинарын товхимлыг энэхүү тайланд тусад нь
хавсаргасан болно)

Хавсралт G Сургалт : Эцсийн тайлан

**Монгол улсын ашигт малтмалын нөөцийн
ангилал (MRCCode/MT Ангилал)**

Дүйцүүлэлт

Зөвлөх мэргэжилтэн,

Б.Оюунгэрэл, Нөөцийн Зөвлөх, Сновден

**(Уул уурхайн яам, Ашигт малтмалын газар,
MSISTAP байгууллагуудад)**

2014.11.26